



ФРАНКФУРТ

ШУУД НИСЛЭГ 6-Р САРЫН 19-С

ПҮРЭВ, НЯМ

ШИНЭ БОИНГ 767-300ER АГААРЫН ХӨЛГӨӨР

Улаанбаатар
10:15

Франкфурт
13:00

Франкфурт
14:30

Улаанбаатар
05:00 (+1)

BOSE
Better sound through research®

VideoWave II

Entertainment system


Гэрийн театрын дуугаралт

1080p дүрслэл

Цогц шийдэл



Сүхбаатар дүүрэг, Их Сургуулийн гудамж 31/1, PC mall
Саммит Компьютер Технологи ХХК, Улаанбаатар-14193, Монгол улс

 7011-3535

 Visit us:
www.pc-mall.mn

 Join us on Facebook
<http://www.facebook.com/PCmallOfficial>

PC mall®

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын сэтгүүлдийн эвлэлийн
“2013 оны Шилдэг сэтгүүл”

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:

Лиззи Хүү

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав / 9409-2904

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох / 9409-2906

“ECONOMY” ТВ СТУДИ

СЭТГҮҮЛЧ:

Ц.Соёлмаа

ЗУРАГЛААЧ:

Ш.Гантуул

КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:

Т.Баярсайхан

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AB center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn



MONGOLIAN ECONOMY
ОНЛАЙН СЭТГҮҮЛ
mongolianeconomy.imedia.mn

АГУУЛГА

ЭДИЙН ЗАСАГ

10 Идэвхжүүлэх төлөвлөгөө ба иргэдийн хүлээлт

|| P10



12 Шинэчлэл нийгэмд татвар төлдөг соёлыг төлөвшүүлнэ

14 Татварын шинэчлэлийн талаар та ямар бодолтой байна вэ?

16 *Цогтцэцийгээс Гашуунсухайт хүртэлх саарал амьдрал-3*
Цагаан хадан дахь бараан амьдрал

|| P16



19 Ирээдүйг гэрэлтүүлэх “Мөрөөдөл” цогцолбор

22 Татварын шинэчлэл хийх тохиромжтой цаг

23 Хөрөнгийн биржэд хөл ургасан уу

25 Ирээдүйгээс зээлсэн өрийн зарцуулалттай танилц

26 Дархлаагүй Монголбанк

28 Эрэлт, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс

30 Ерэн жилийн хөгжил

32 Мэдээлэл технологийг гарамгай зээмшсэн 10 орон

34 Б.Төмөрчулуун: Манай төр ёолкны мод шиг байна

34 2013 оны дэлхийн хамгийн муу захирлууд

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МНН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Гийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетийн бүх салбар

“Макс” супермаркетийн бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар

“Max mall” салбарууд



facebook.com/Mongolian.
Economy



twitter.com/EconomyMon-
golia




youtube.com/user/Mongo-
lianEconomy

RECLAM6S.MN

Гарч хайснаас гараасаа хай...

Та reclam6s.mn сайтад бараа бүтээгдэхүүнээ реклам, видео зар сурталчилгаатай нь хамгийн хямд үнээр байршуулах боломжтой.


Таны худалдаа үйлчилгээг бид түгээнэ.



ВЭБ, МОБАЙЛ ВЭБ БОЛОН APPLICATION

3

ХОСОЛСОН ҮЙЛЧИЛГЭЭ



91116586, 96606586


Бид хамтран ажиллахдаа таатай байх болно.



MICROSOFT-ийн бүтээгдэхүүнийг албан ёсоор танилцуулж байна



MicroSoft
Windows 8 Pro



MicroSoft
Office 2013



MicroSoft
HD WebCamera




MicroSoft
Wireless Mouses



MicroSoft
Wireless Keyboard

Зөвхөн PC MALL-ийн салбар дэлгүүрүүдээр

Сүхбаатар дүүрэг, Их Сургуулийн гудамж 31/1, PC mall
Саммит Компьютер Технологи ХХК, Улаанбаатар-14193, Монгол улс



PC mall

МОНГОЛД

Хөдөө аж ахуй

Хөдөө аж ахуйн биржийн арилжаагаар ойрын хугацаанд амьд мал оруулахаар байгаа аж. Биржээр амьд мал оруулна гэдэг нь шинэ ойлголт учраас одоогоор биржийн брокеруудыг чадавхижуулах сургалт зохион байгуулж байгаа юм байна. Ийнхүү ХАА-н биржээр амьд мал арилжсанаар малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ, нөөцийг тогтвортой байлгахад чухал ач холбогдолтойг албаныхан онцолж буй. Хөдөө орон нутгаас авчирсан малыг хотын хоёр захад хүлээн авах ажээ. Тодруулбал, баруун талаас ирэхийг “Эмээлт”-ийн захад, зүүн талаас Налайх дүүргийн түүхий эдийн захад хүргэлтийн цэг байгуулах юм байна.

Технологи

Экспортыг дэмжих, импортыг орлох судалгааны 888 төсөл дотор дотоодод гар утас үйлдвэрлэх дөрвөн төсөл бий аж. Тухайлбал, ITZone компани Android 4.1 үйлдлийн системтэй, дөрвөн инчийн дэлгэц бүхий “Mogul” брэндийн ухаалаг утсаа 150 000 төгрөгөөр борлуулна гэдгээ хэллээ. Зөвхөн гар утасны хэрэглээнд жилд дунджаар 48 тэрбум төгрөг гадагшаа гардаг аж.

Уул уурхай

Хөшөөтийн уурхайгаас нүүрс олборлон, экспортлох ажлыг ирэх долдугаар

сараас эхлүүлэхээр болжээ. Ховд аймгийн нутагт орших уг нүүрсний ордын хөрс хуулах ажлыг “Моннис майнинг экьюпмент” компани хийх аж. Тус компани нь аймгийн Засаг даргатай хийсэн хамтран ажиллах гэрээний дагуу орон нутгаас ажиллах хүч авах, бараа бүтээгдэхүүнийг орон нутгаас худалдан авах зэрэг үүрэг хүлээсэн байна.

Хууль

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бэлэн болгожээ. УИХ-ын намрын чуулганаар уг төслийг өргөн барих юм байна. Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд цалингийн гэрээг боловсронгуй болгож албан байгууллагуудын хариуцлагыг сайжруулах, албан бус хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн маргааныг богино хугацаанд шийдвэрлэх, ажлын байрны дарамт шахалт зэргийг нарийвчлан тусгаж өгчээ. Мөн олон улсын байгууллагын хөдөлмөрийн тухай хуулийн жишгээр ижил хөдөлмөр эрхэлж байгаа дотоод, гадаадын ажилчид болон хүйс ялгахгүйгээр ижил цалин авах асуудлыг хуульчлахаар болсон байна.

Татвар

Манай улсын энэ оны төсвийн орлого 6.9 их наяд төгрөг. Үүний 90 хувь буюу 6.2 их наяд төгрөгийг

татварын орлогоор бүрдүүлэх юм. Үлдэж буй 10 хувь буюу 0.7 их наяд төгрөгийг татварын бус орлогоос төвлөрүүлнэ. Хөрөнгийн орлого 476 сая төгрөг байгаа. Татварын орлогын 27 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/, 17 хувийг нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/ тус тус бүрдүүлэх аж.

Шинэчлэл

Төрийн байгууллагуудаас олгодог зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлж, шат дамжлагыг нь хялбарчлах ажлыг эхлүүлээд байгаа. ЗГХЭГ-аас төрийн 54 байгууллагаас олгож байгаа нийт 914 зөвшөөрлийн 478-ыг нь хүчингүй болгож, 436 зөвшөөрлийг хэвээр үлдээхээр шийдвэрлэлээ. Зөвшөөрлийн 52.29 хувийг хүчингүй болгож 47.4 хувийг өөрчилхөөр болсон байна. Дараагийн ээлжинд одоо мөрдөж байгаа 59 хууль, 45 журамд өөрчлөлт оруулах буюу хүчингүй болгох шаардлагатай. Мөн “Зөвшөөрлийн тухай” шинэ хууль гарган энэ төрлийн үйл ажиллагааг цэгцлэхийг зорьж байна. Одоогоор шинэ хуулийн үзэл баримтлалыг боловсруулж дуусаад байна.

Бүтээн байгуулалт

Хуурай технологийн аргаар жилд нэг сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай шинэ үйлдвэр энэ сарын 14-нд ашиглалтад орлоо.

Ингэснээр дотоодын нийт цементийн хэрэгцээний 50 хувийг тус үйлдвэр дангаар хангах боломжтой болж байгаа юм. Өнгөрсөн онд манай улс 1.8 сая тонн цемент хэрэглэсэн бөгөөд үүний 60 гаруй хувийг импортоор худалдан авчээ. Шинэ үйлдвэр нь Хөтөлийн “Цемент шохой”-н үйлдвэрийн дэргэд сүндэрлэн боссон төдийгүй үндэсний хөрөнгө оруулагч “Бэйзмент” компани энэхүү төслийг хэрэгжүүлжээ. Төсөлд нийтдээ 250 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулахаас 157 тэрбум төгрөгийг бүтээн байгуулалтад зарцуулаад байна. Хоногт гурван мянган тонн цемент үйлдвэрлэх шинэ үйлдвэрийг зургаан сарын хугацаанд ашиглалтад оруулжээ.

Аж үйлдвэр

Мега төслүүдийн нэг нь Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор. Тус паркийн эхний ээлжийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад 200 сая ам.доллар шаардлагатай байгаа аж. Цогцолбор байгуулахад гангийн үйлдвэрт 3.5 тэрбум ам.доллар, дэд бүтцийг хөгжүүлэхэд хоёр тэрбум ам.доллар, нийт 5.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоог “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” хувьцаат компаниас гаргажээ. Цогцолбор ашиглалтад орсноор нийт 10 мянган ажлын байр шинээр нэмэгдэх юм.

ДЭЛХИЙ ДАХИНД

БНХАУ

Хятадын “Алибаба” цахим худалдааны компани Нью Йорк хотноо ойрын үед анхдагч зээлд хувьцаа гаргахаар төлөвлөөд буй. Гэхдээ яг хэзээ гаргах нь тодорхойгүй байна. Уг компани 2012 онд 160 тэрбум ам.долларын борлуулалт хийсэн нь салбартаа тэргүүлэгч “Амазон”-ы орлогоос даруй хоёр дахин их болохыг Nasdaq хөрөнгийн бирж мэдээлжээ. “Алибаба” компани өнгөрсөн оны аравдугаар сард 120 тэрбум, харин өдгөө 153 тэрбум ам.доллараар үнэлэгдэж буй. Энэ нь түүхэндээ хамгийн өндөр үнэлгээ болох аж.

Тайланд

Тайландын Ерөнхий сайд хатагтай Йинлук Шинаватраг тус улсын шүүх албан тушаалаа урвуулан ашигласан хэмээн буруутгаж, албан тушаалаасаа буухыг шаардсан. Уг шүүхийн тогтоол нь өнгөрсөн оны аравдугаар сараас хойш Бангкок хотод үүсээд байсан эсэргүүцэл, тэмцлийг улам ч хурцатгав бололтой. 2006 онд Ерөнхий сайдын сэнтийгээс буусан Таксин Шинаватра буюу төрсөн ахдаа зуучилсан гэж түүнийг буруутгасан аж. Йинлик нь ахтайгаа холбоотойгоор албан тушаалаасаа огцорч буй гурав дахь Ерөнхий сайд болжээ.

Крымийн Бүгд Найрамдах Улс

Крым улсын ард иргэдийн

дунд ОХУ-тай нэгдэх эсэх талаар олон нийтийн санал хурааж буй. Урьдчилсан байдлаар тэдний 95.5 хувь нь нэгдэхийг дэмжсэн талаар ВВС агентлаг мэдээлэв. ОХУ-тай нэгдэх талаарх өргөдлийг энэ сарын 19-нд өргөн барьж буй. Ерөнхийлөгч Путин Крымийн ард иргэдийн хүсэл, эрмэлзлийг хүндэтгэх болно гэдгээ мэдэгдсэн. Энэхүү маргаантай асуудлын тал дээр барууны орнууд болон Японы зүгээс Орост тавьсан эдийн засгийн хоригт Путинтэй санхүү болон улс төрийн хувьд дотно холбоотой хүмүүс, бизнесмэнүүд багтай буйг CBC News мэдээлсэн байна.

Турк

Турк улсад уурхайн дэлбэрэлтээс болж амиа алдсан хүний тоо 300 дөхөж байгааг Wall Street Journal мэдээлжээ. Цахилгаантай холбоотой үүссэн

дэлбэрэлтийн үеэр уурхайд нийт 787 хүн байсан болов уу гэж таамаглаж буй. Угаарын хийнээс болж олон хүн амиа алдаад байна. Аврах багийнхан амьд гарсан уурхайчдыг олж, гаргахын тулд шургуу ажиллаж буй. Тус улсын уурхайн аюулгүй байдал нь үйлдвэрлэл хөгжсөн бусад орныхоос хоцрогдсон хэмээн шинжээчид үзэж байна.

Австрали

Тони Абботтын удирдсан Засгийн газар Австралийн нэгдсэн төсвийг өнгөрсөн долоо хоногт анх удаа гаргав. Уг төсөвт эдийн засагт дахин илүүдэл үүсгэхэд чиглэсэн хатуу арга хэмжээнүүд тусгажээ. Тухайлбал, ирэх таван жилд гадаад тусламжийн хэмжээг 7.6 тэрбум австрали доллараар танахаар болсныг ABC агентлаг мэдээлжээ.

Харин Монголд үзүүлэх тусламжийг нэмэгдүүлэхгүй, харин хэвээр хадгалах магадлалтай аж. Энэ нь “Оюутолгой”-н үйл ажиллагаатай холбоотой гэжээ. Өнгөрсөн гуравдугаар сард Австралийн Гадаад хэргийн сайд Жули Бишоп хоёр улсын хоорондох “Олборлох хөтөлбөр”-ийн хүрээнд хорин сая австрали долларын санхүүжилт өгөхөө мэдэгдсэн юм.

Технологи

Apple компани хамгийн сүүлийн үеийн iPhone 6 загвараа ирэх наймдугаар сард гаргах хүлээлттэй байгааг “Ройтерс” мэдээлсэн байна. Шинэ загвар нь улам гялалзсан, нимгэхэн, илүү хурдтай болох аж. Мөн дэлгэцийн хэмжээгээ томруулж байгаа нь гар утасны зах зээлд Samsung-тай илүү өрсөлдөхүйц болгох аж. ■



ОНЦЛОХ

ИДЭВХЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ
БА ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТ

И.ОТГОНЖАРГАЛ

Сүүлийн үед сургууль, цэцэрлэг, хаана л албан байгууллагын хаалга татна хаа сайгүй эдийн засаг 100 хоногт эрчимжих үү гэдэг асуултыг сонирхох хүн олон. Цэцэрлэгийн цэвэрлэгч хүртэл энэ талаар мэдэхийг хүсэж байна. Ам.долларын тэнгэрт хадсан ханш гурил будаа, талх тариа, тараг сүүний үнийг хөөрөгдсөөр байгаа учраас хэн хүнгүй Засгийн газраас зарласан 100 хоногийн талаар ийнхүү сониучирхах нь аргагүй. Нийгмийн нэлээд уншдаг судалдаг хэсгийн зарим нь “Үр дүн гарахгүй дээ, есдүгээр сард улс төрийн шоу байжээ гэдэг нь харагдана” гэх. Нөгөө хэсэг нь “Ямар ч гэсэн “давхар дээл тайлах” гэдэг ч юм уу хий дэмий асуудлаар хэрэлдэж суухаар нь хүнд үед УИХ-ын тогтоол гаргаж, Засгийн газар ажил хийх гээд зүтгэж байгааг нь сайшаах хэрэгтэй. Үр дүн гарна” хэмээн итгэл тээх аж. Манай сэтгүүлийн хувьд үр дүн гарна гарахгүй гэдгийг урьдчилан тааварлах гэсэнгүй. Болж байгаа үйл явдлыг тоймлон дүгнэхийг чухалчиллаа.

100 хоногийн хугацаанд Засгийн газар юу хийх тухайгаа тавдугаар сарын 16-ны УИХ-ын чуулганд Ерөнхий сайд Н.Алтанхуяг мэдээлэл хийсэн. 100 хоногт хийх 70 ажлыг зургаан бүлэгт хуваасан байна. Бизнес эрхлэгчдийг дэмжих, Уул уурхай ашигт малтмалын салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, Барилга, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарыг эрчимжүүлэх, Аймаг орон нутгийн дэд бүтэц, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх болон Төсөв, мөнгөний бодлогын хүрээнд ажлууд хийхээр төлөвлөжээ. Муугүй төлөвлөгөө санагдсан ч 100 хоногт яагаад ч амжуулахааргүй

өргөн цар хүрээтэй асуудлуудыг багтаажээ. Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх УИХ-ын тогтоол ч мөн л 100 хоног битгий хэл, 3-4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр өргөн агуулгатай чиглэл өгсөн байсан. Ихэнх нь хууль эрх зүйн зохицуулалт, том бүтээн байгуулалт шаардсан ажлууд байгаа нь харин богино хугацаанд буюу 100-хан хоногт үр дүн гарна гэж хүлээхэд хэт дэгсдсэн хэрэг болох юм шиг ажиглагдсаныг нуух юун. Эрчимжүүлэх 100 хоногийн тоолуур 2014 оны тавдугаар сарын 10-наас гүйж эхэлснийг Ерөнхий сайд хэвлэлийнхэнд албан ёсоор мэдэгдсэн. Түүнчлэн 100 хоног дуусахад үр дүн гарна гэдгийг ч Засгийн тэргүүн амласан. Нөгөө талаас ажлаа сайн хийдэггүй муу сайд нарыг огцруулж, Засгийн газрыг чинь ганхуулна шүү гэсэн улс төрийн шантааж шахалт дунд шинэчлэлийн Засгийн газар зүтгээд үзэхээс аргагүй. Ийнхүү хаана хаанаа шахалт байгаа нь үр дүн гаргах үндэс ч байж болох. Учир нь тэдэнд цаг алдах, алгуурлах эрх байхгүй. Сүүлийн хэдхэн хоногт чухал шаардлагатай хэд хэдэн хуулийн төсөл өргөн барьж амжив.

Ерөнхий сайд дэргэдээ төр, хувийн хэвшлийн төлөөллөөс бүрдсэн 30 хүний бүрэлдэхүүнтэй “Эдийн засгийг эрчимжүүлэх зөвлөл” байгуулсан. Энэ бол түүний багийн 100 хоногт хийх жагсаалтад орсон ажлуудын нэг. Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Ерөнхийлөгчийн тамгын газар, холбогдох яамд, агентлагийн төлөөллөөс бүрдсэн тус зөвлөлийн гишүүдийн тал нь уул уурхай, банк санхүү зэрэг бизнесийн болон



мэргэжлийн холбоодын төлөөлөл байгаа нь өмнө нь байгаагүй шинэлэг бүтэц санагдав. Нөгөө талаас бизнесийг дэмжих үүднээс асуудлыг нэлээд өргөн хүрээтэй харж, боловсруулах гэсэн зорилго өвөртөлсөн гэлтэй. Тус зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга ▶

▶ Б.Бямбасайханаас хийж буй ажлынх нь талаар асуухад “Өмнө нь аливаа асуудалд Засгийн газар бизнесийнхний саналыг авдаг. Гэвч тэр санал нь бодлогод тусгагдахаасаа тусгагдахгүй нь их. Тэгвэл энэ удаа Ерөнхий сайдын захирамжаар эдийн засгийг эрчимжүүлэх зөвлөлд бизнесийн нэлээд өргөн бүрэлдэхүүнтэй баг ажиллаж байна. Бид нэгэнт цаг заваа зориулж байгаа учраас ажлаа эхлэхээсээ өмнө өөрсдийн зүгээс гаргасан санал санаачилгаа бодлогод тусгуулах тал дээр бодитой хандахыг

нөгөө хэсэгт нь муу нөлөөтэй байгаа. Үүнийг яаран шийдэх шаардлагатай гээд түр гал унтрааж аргацаасан арга хэрэглэхээсээ илүү гарц шийдлийг олох процесст зөв хүмүүс орж, системийн шинэчлэл хийх шаардлагатай байна. Монголын асуудлыг монголчууд өөрсдөө л шийднэ. Ингэхдээ төр+бизнес +иргэний оролцоог жинхэнэ утгаар нь хангаж байж өсөлтийг хангасан тогтолцоог бүрдүүлж чадна. Тийм болохоор бизнес эрхлэгчид маш тодорхой зүйлүүдээр саналаа боловсруулна. Тухайлбал, өсөлтийг

зорилгоор Тавантолгой-Ханбогд – Ханги чиглэлийн авто зам төслийн Концессын гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн, Алтанбулагийн чөлөөт бүсэд хөрөнгө оруулалт татах, Өрийн удирдлагын тухай хуулийг өргөн барьсан гээд Засгийн газарт эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр хийж байгаа бодитой ажлууд бий. Нөгөө талаас эдийн засгийг идэвхжүүлэх ажлын төлөвлөгөөг харахад ирээдүйгээ чиглэсэн сууриар нь засах зохицуулалтууд цөөнгүй тул нийт хийх ажлынхаа төлөвлөгөөг богино, дунд, урт хугацаанд гэж ангилж зааглаагүй нь хүмүүст хэт алсыг харсан 100 хоног гэдгээ умартсан мэт сэтгэгдэл үлдээх магадлалтай. Түүнчлэн Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал хэвлэлд өгсөн ярилцлагадаа хаврын улирал дуусангуут вальютын орох урсгал нэмэгддэг тухай хэлсэн байсан. Нээрээ ч тийм байх талтай Улсын баярыг эс тооцвол зуны саруудад Цагаан сар, Шинэ жил шиг худалдан авалтыг урамшуулсан тэмдэглэлт өдөр цөөн. Дээр нь амралтын улирал учраас хүмүүс хөдөө гадаа амарч зугаацах нь их. За тэгээд нэгэнт улирал нь ирсэн учраас уул уурхай, барилга, аялал жуулчлалын салбар УИХ-ын тогтоолтой тогтоолгүй, Засгийн газрын 100 хоногтой хоноггүй тодорхой хэмжээгээр идэвхжиж, валютын урсгалыг нэмэгдүүлэхэд нөлөөтэй оролцох нь мэдээж. Ялангуяа аялал жуулчлалын тухайд энэ жил Монгол Улсыг дэлхий дахинд сурталчилах нөхцөл бүрдсэн учраас өмнөхөөс ч сайхан ирээдүй харагдаж байгаа тухай мэргэжлийн хүмүүс тэмдэглэж байна. Ийнхүү эдийн засгийн амьдрал эерэг байх үетэй 100 хоногийн арга хэмжээ давхцаж байгаа нь Засгийн газрыг хийсэн зүйлтэй харагдуулж аврах тактик ч байж болох. Тавдугаар сарын 10-наас наймдугаар сарын дунд үе хүртэл эдийн засаг идэвхжсэн үү идэвхжсэн. Энэ нь 100 хоногийн арга хэмжээний үр дүн гэж үзэхгүй байх аргагүй. Гэхдээ 100 хоногийн үр дүн амьдрал идэвхждэг есдүгээр сард ямар байхаас л харагдана. Хэрвээ үр дүнгүй зүйл байх аваас хэрэглээг дэвэргэдэг есдүгээр сард байдал бахь байдгаараа л байна гэсэн үг. Зун ам.долларын дотогшлох урсгал сайжирдаг бол жил бүрийн намар хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотой ам.долларын эрэлт ихсэж, ханш өсдөг уламжлалтайг мартаж болохгүй. ■



Эдийн засгийг идэвхжүүлэх тухай УИХ-ын тогтоол нэлээд өргөн агуулгатай гарчээ

Ерөнхий сайдтай тохиролцсон байгаа. Тийм болохоор системийн шинэчлэлийн асуудлаар ч тодорхой санал санаачилга гаргаж, хөрсөө сайн бүрдүүлэх чиглэлд ажиллана” гэв. Тэрбээр өнөөдөр ам.долларын ханш 1820 төгрөгт хүрсэнийг тийм ч болохоо байсан зүйл гэж харахгүй байна. Ханшийн өсөлт нь нийгмийн нэг хэсэгт нь сайн,

ханагасан татварын тогтолцооны үндсийг тавих ёстой” гэлээ.

Монгол Улсад визгүй зорчих орны тоог нэмэгдүүлж, жуулчны тоог өсгөх, Ипортын гаалийн болон НӨАТ-аас аж ахуйн нэгжийг түр чөлөөлөх хугацааг 2016 оныг дуустал мөрдөх, Хувийн хэвшлийг дэмжих

ТАТВАР

ШИНЭЧЛЭЛ НИЙГЭМД ТАТВАР ТӨЛДӨГ СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ

И.ОТГОН

Татварын шинэчлэлийг хүн бүрийн сонирхлыг татаж байна. Бизнесийнхний дуу хоолой ч энэ тал дээр тодорхой гарч эхэллээ. Гэхдээ төр засгийн түвшинд шинэчлэлийг хэрхэн харж байгаа, ямар үе шаттай хийх талаар одоогоор олон нийтэд төдийлэн мэдээлэл алга. Тиймээс Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын Орлогын хэлтсийн дарга Э.Батбаяртай энэ талаар ярилцлаа.



-Татварын II үе шатны шинэчлэлийг 2014-2017 онд хийнэ гэдгийг Засгийн газар зарласан. Өнөөдрийн байдлаар төр, засгийн түвшинд татварын шинэчлэл ямархуу шатанд явна вэ. Нийт хэчнээн хуулийн төсөл өргөн бариад, хэзээ хэлэлцэхээр байна вэ?

-Татварын хуулийн шинэчлэлтэй холбоотой Засгийн газрын ажил өнгөрсөн оноос эхэлсэн. Сангийн яам боловсруулсан хуулийн төслөөрөө

өнгөрсөн оны сүүлийн хагасаас яамдаас санал аваад, УИХ-д хоёр хуулийн төсөл өргөн барьсан байгаа. Хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон НАӨТ-ын босгыг өндөрсгөх, ААНОАТ-ын 90 хувийг буцаан олгох тухай хоёр хуулийн төсөл юм. Хуулийн төслүүдийн тухайд НӨАТ-ын босго одоо бол 10 сая төгрөг байдаг. Үүнийг 50 сая төгрөг болгож өндөрсгөсөн. Яагаад гэхээр бичил үйл ажиллагаа эрхэлж байгаа хүмүүсийн тайлан тушаахтай холбоотой гарч байгаа зардал нь татварын орлоготой нь харьцуулахад өндөр, дарамттай байгаа учраас энэ хэсгийг дэмжих үүднээс ийм арга хэмжээ авч буй. 10-50 сая төгрөгийн борлуулалтын орлоготой хүмүүс НӨАТ төлөгчөөр сайн дураар бүртгүүлэх эрх нь нээлттэй. Зөвхөн НӨАТ-ын босгыг нэмэгдүүлэх хуулийн төслийг өргөн барьсан. Үүнээс гадна НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгыг мөн хийсэн байгаа. НӨАТ хэрэглээний татвар. Дэлхийн олон оронд хэрэглэдэг. Эцсийн хэрэглэгч уг татварыг төлдөг, буцаан олголттой татвар.

-Засгийн газар Татварын шинэчлэлийн хүрээнд хувь хэмжээг нэмэхгүй гэж мэдэгдсэн. Гэтэл бизнес эрхлэгчид дөрвөн “5”-ын тогтолцоо руу шилжих шаардлагатай татварын тухай яригдаж байна. Үүнийг хуулийн төслүүдтэй хэрхэн хамааруулж авч үзэх вэ?

-Татварын одоо байгаа хувь хэмжээг өсгөхгүй. Аль нэг татварыг барьж авч шинэчлэх гэхээсээ илүү татварын хуультай хамааралтай холбогдох дүрэм журмуудыг шинэчлэн

сайжруулах шаардлага үүссэн. Жишээлбэл, НӨАТ-ын падаантай холбоотой олон төрлийн маргаан гарч байна. Бид 1990 оноос хойш гарсан татварын маргаануудыг судалж үзсэн. 2008 оноос эдийн засаг эрчимжсэн учраас хуулийн төрөл бүр дээр гардаг маргаан ихэссэн. Манай одоогийн хуулийг татварын байцаагч нэг өөрөөр уншиж ойлгодог, татвар төлөгч бас нэг өөрөөр ойлгодог, олон салаа утгатай байгаа. Тийм болохоор хуулийг энгийн ойлгомжтой, бүх хүн нэг үгээр ойлгодог болоход энэ удаагийн татварын шинэчлэл нэлээд чухал. Үүнээс гадна сүүлийн жилүүдэд бизнесийн харилцаа өргөжиж байгаа учраас олон улсад хэрэглэгддэг нэр томьёо зарчмуудыг оруулж ирэх шаардлага гарч ирж байна. Өнгөрсөн оноос татварын электронжуулалтыг маш сайн эхлүүлсэн. Өнөөдөр гол нэр төрлийн татваруудыг цахимаар тайлагнадаг системд шилжсэн. Үүнийг хуульдаа тусгаж өгөх асуудал бий. Мөн санаатай болон санамсаргүйгээр алдаа хийсэн татвар төлөгчдөд хариуцлагыг хэрхэн ногдуулах, маргааныг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудалд маш тодорхой зохицуулалт хийх шаардлагатай.

-Хуулийн шинэчлэлийг хийхийн тулд хэчнээн хуульд гар хүрэх шаардлагатай байна. Ямархуу үе шаттай явах вэ?

-Хуулиудаа бид дөрвөн төрөлд хуваасан. Нэгдүгээрт, шинэчилсэн найруулга. Татварын ерөнхий хууль, ААНОАТ тухай хууль, Хувь хүний орлогын албан таварын тухай хууль, НӨАТ-ын тухай хууль, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тухай хууль гэсэн төрлүүд ▶

▶ шинэчилсэн найруулгаар явна. Мөн ижил төрлийн хуулиудыг нэгтгэх ажил хийгдэнэ. Энд хөрөнгийн татварын хуулиуд нэгтгэгдэж байгаа. Ашигт малтмалын хууль, Нөөцийн төлбөрийн тухай хуулийг нэгтгэнэ. Өмнө нь Ашигт малтмалын тухай хуулиар ашигт малтмалын нөөцийн төлбөрийг зохицуулдаг байсан бол үүнийг Татварын тухай хуулиар зохицуулдаг болох гэж байгаа. Мөн газрын тосноос нөөц ашигласны төлбөр гэж авдаг. Үүнийг хуульчилж энэ хоёр төрлийн нөөцийн төлбөрийн тухай хуулиа нэгтгэх гэсэн байдлаар санал боловсруулсан байгаа. Гуравдугаарт, Монгол Улсад эдийн засгийн утгаараа заавал байх ёстой хэрнээ хэрэглэдэггүй хуулиуд байгаа. Үүнийг хэрэгжүүлдэг болно. Жишээ нь Өв залгамжлал, бэлэглэлийн тухай хууль байдаг. Үүнийг хүмүүс шинээр татвар авах гэж байгаа мэт хараад байна. Энэ бол шинэ татвар биш. Байгаа хуулиа зөв хэрэглэх тухай асуудал юм. Жишээ нь, үл хөдлөх хөрөнгийн худалдалдаг өнөөдөр манайхан таньдаг таньдаггүй хамаагүй бүгд бэлэглэлийн гэрээгээр хийдэг болсон. Энэ бол буруу зүйл юм. Дөрөвдүгээрт, нэмэлт, өөрчлөлт орж байгаа хуулийн төслүүд бий.

-Хаврын чуулганаар эдгээрийг бүгдийг оруулж амжих уу?

-Татварын асуудал салбар ч биш, Монгол Улсыг бүхэлд нь хамарсан маш өргөн хүрээтэй асуудал. Ийм чухал асуудлаар олон хуулийг нэг зэрэг оруулах боломжгүй. Тийм болохоор бага багаар оруулна. Эхний ээлжинд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан эдийн засгийг дэмжиж байгаа хэсгийн хуулийн төслийг хугацаа алдалгүй оруулах юм. Энэ үүндээс хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад НӨАТ-ын босгыг нэмэгдүүлэх болон ААНОАТ-ын 90 хувийн буцаан олголт гэсэн хоёр хуулийн төсөл орсон байгаа. Хуулийн төслүүд жижиг, дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг нэлээд дэмжих юм. Ер нь татварын багц хуулийн шинэчлэлийн асуудлыг намрын чуулганаас нэг их хэтрүүлэхгүй байх бодолтой байгаа. Энэ хүрээнд өөрчлөлт орох томоохон татварын хуулиуд нь дээр хэлсэн 4-5 төрлийн татварын хууль. Бусад нь харилцааг

нь тодорхой түвшинд хязгаарлаж болох харьцангуй жижиг хуулийн төсөл. Жишээлбэл, Бууны албан татварын тухай хууль ч гэдэг юм уу.

-Мэдээллийн технологийг сайжруулах чиглэлээр ямар шинэчлэл байж болох вэ?

-Энэ бол шинэчлэлийн хүрээнд хийгдэх нэлээд чухал асуудлын нэг. Технологийн асуудлыг бүртгэлжүүлэх систем гээд ойлгож болно. Хэн хэдэн төгрөгийн орлого олдог вэ гэдэг бусад улсад бүртгэлтэй байдаг. Манайд тийм биш. Үүнийг хийх юм. Үүнээс гадна бид татвар төлөгчдөө маш сайн боловсролтой болгох, нийгэмд татварын соёлыг төлөвшүүлэх асуудал чухал байна. Тэгш шударга гэдэг хүн бүр өөрийн орлогоосоо тодорхой хэмжээний татварыг төлөх зайлшгүй шаардлагатай. Өнөөдөр 100 сая төгрөгийн борлуулалт хийчихээд би жижиг гээд суугаад байх уу гэдэг асуудал. Ижил орлоготой хүмүүс татвараа адил тэнцүү төлөх ёстой. Гэтэл манайд өнөөдөр татвар төлдөг соёл төлөвшөөгүй байгаа учраас хүмүүс татвараас зугтахыг чухалчилдаг. Татварын орлогыг нь тодорхойлоод татвар төлдөг болгох гэхээр намайг дарамталсан гэсэн ташаа ойлголт түгээх жишээтэй.

-Өнөөдөр бизнесийнхэн саяын таны ярьсанчлан бүртгэлийн системээ сайжруулж, татвараа бүгдээс нь адилхан авах асуудлыг хүчтэй тавьж байна. Татвар хураалт дээр төр зардал гаргахаас эмээж, “Номхон тэмээ ноолоход амар” гэдэг шиг бүртгэлтэй хэдийгээ л байнга татвараар дарамталдаг гэсэн гомдол санал их бий. Энэ тал дээр та юу хэлэх вэ?

-Мөн л нөгөө иргэдийн татвар төлөх соёл суугаагүйтэй холбоотой асуудлыг ярих болох нь. Бүртгэлд самруулаад татвараа авъя гэхээр ихэнх нь бүртгэлгүй байгаа учраас сайн ойлгож өгөхгүй байна. Жишээ нь 100 айлын барилгын дэлгүүрүүдэд маш олон төрлийн бараа зарагдаад, барилгын салбарыг хөгжүүлээд явж байгаа хэрнээ татвар төлөхгүй байна гэдэг татвар төлөх соёл суугаагүй байна гэсэн үг. Үүнийг бид бүртгэлээрээ сайжруулж ёстой. Өнөөдөр зөрчлийг шийдэх гэхээр

иргэдийн ихэнх нь татвар төлөөгүй, нуусан гэсэн хариуцлагад орох болдог. Нийгмийг татвар төлдөг соёл хэвшүүлэх нь чухал. Хуулиа чангатгах ч юм уу ажил хийлээ гээд системийг нь бүрдүүлж өгөхгүй бол магадгүй маргааш бүх хүн адилхан хуулийн өмнө хариуцлага хүлээх асуудал гарч ирэхийг үгүйсгэхгүй. Тийм болохоор системийн ойлголт өгөх, түүний араас хууль нь орох байдлаар дэс дараалалтай явах юм.

-МҮХАҮТ-ын татварын дөрвөн “5”-ын бодлого руу шилжих асуудлын тухай та мэргэжлийн хүний хувьд ямар тайлбар өгөх вэ?

-Сангийн яам татварын шинэчлэлийн асуудлаар харьцангуй ардчилсан байдлаар ажилласан гэж хэлж болно. Монголын бизнес эрхлэгчдийн холбоо, танхим, банк зэрэг салбараас санал аваад явж байгаа. Хүн бүрийн хүссэнийг хуульд нь оруулах боломжгүй. Татвар гэдэг төсвийн орлогыг бүрдүүлээд, бизнес эрхэлж байгаа хүмүүс болон ард иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг үзүүлэх ёстой. Жишээ нь НӨАТ-аар нэг их наяд төгрөгийн орлого төсөвт төвлөрдөг. Үүнээс тодорхой хэмжээгээр НӨАТ-ын буцаан олголт хийдэг. Дөрвөн 5-ын бодлого хэрэгжүүлбэл энэ орлогын тал нь байхгүй болно гэсэн үг. Тэгэхээр та бүхэн сайн ойлгоорой, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний тал нь байхгүй болох нь гэж хэлэх байна. Авто зам хэрхэн сайжирсан, сургууль, цэцэрлэгүүдийн тоо хэд болж нэмэгдэж байгаа, бизнес эрхлэх боломж хэр өсөж байгаа гэх мэтчилэн төрөөс үзүүлж буй үйлчилгээг давхар сайн бодож үзэх хэрэгтэй. Татвар гэдэг бол ганцхан бизнес хийх шийдвэр биш. Манай татвар бусад улстай харьцуулахад Азид төдийгүй дэлхийд харьцангуй доогуур. Заавал бид дөрвөн 10, дөрвөн 5 гэсэн зарчим хэрэглэхгүй ч байж бас болно. Ашгийн татвар эсвэл хэрэглээний татварыг нь өөрчлөх ч гэдэг юм уу арай өөрөөр асуудлыг тавьж болно. Түүнээс биш, дөрвүүлэнг нь зэрэг буулгаад, таван жил тутамд татвараа бууруулсаар яваандаа 0 татвартай болъё гэж бодъё. Тэгэхээр монголчуудын боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах энэ бүхэн юу болох вэ. ■

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР ТА ЯМАР БОДОЛТОЙ БАЙНА ВЭ?

Л.ХҮРЭЛБААТАР /“Монос групп”-ын ерөнхийлөгч/:

-Татварын өнөөгийн орчныг тийм ч муу гэж үзэхгүй байна. Шинэчлэлийн тухайд орлого олсон л бол бүх нийтээрээ төлдөг болгомоор байгаа юм. Бүгд л төлөх хэрэгтэй. НӨАТ-ын тухайд босгын тухай асуудал их ярьдаг. Энэ тал дээр би эсрэг байр суурьтай байдаг хүн. Тэдээс дээш орлоготой нь татвар төл гэх нь буруу. Түүнийхээ оронд ямар ч босгогүй болгоод бүх нийтээрээ татвар төлдөг байх нь зөв. Гэхдээ татварын хөнгөлөлт, урамшууллын тогтолцоо байх нь зүйн хэрэг. Нөгөө талдаа бид шинэчлэл гээд л яриад байдаг. Гэтэл Монголд хууль дүрэм маш олон

“ Ер нь нэг хэсэг нь татвар төлөөд нөгөө хэсэг нь татвар төлдөггүй байж болохгүй. ”

байна. Хуулийн хэрэгжилт хэр байна вэ. Өнөөдөр 100 гаруй жил хуулиа өөрчлөөгүй орон байж л байна шүү дээ. Үүний учир нь тухайн хуулиа ягштал дагаж мөрддөг л байгаа юм. Тиймээс бид өмнө нь гаргасан зөв хууль дүрмээ дагаж мөрдөөд болохгүй байгааг нь цаг тухайд нь засаж залруулаад хэрэгжүүлэхэд нь анхаармаар байна.

Ч.НЭРГҮЙ /МУХАҮТ-ын бодлого төлөвлөлт, зохицуулалтын газрын дарга/:

-Өнөөгийн татварын орчныг нэг үгээр тодорхойлбол “дарамттай” байна. Ганцхан жишээ дурдахад бизнес эрхлэгчид орлогынхоо 40 гаруй хувийг татварт өгч байгаа гээд бод доо. Нөгөө талдаа татварын байгууллагын боловсон хүчний мэдлэг чадвар дутуу дулимаг. Төрийн нэрээр хувийн хэвшлийг дарамталдаг. Эндээс татварын орчныг эрс шинэчлэх цаг нь болжээ гэдэг нь харагдана. Татварын тал дээр МҮАХҮТ-аас олон шинэ санал санаачилга гаргаад

“ Ажлын байр нэмэгдүүлэх тусам нь нийгмийн даатгалын дарамт ихэсдэг. Тиймээс энэ төрлийн татварын багасгах хэрэгтэй байна. ”

явж байгаа. Дөрвөн “10”-ын бодлогоос дөрвөн “5”-ын бодлого руу шилжих гэх мэт. Татвартай холбоотой өөр нэг асуудал бол нийгмийн даатгал юм. Ажил олгогчид энэ татвартай холбоотой дарамтад байнга ордог. Ажлын байр нэмэгдүүлэх тусам нь нийгмийн даатгалын дарамт ихэсдэг. Тиймээс энэ төрлийн татварын багасгах хэрэгтэй байна.

Г.ГАНБОЛД /“Монгол алтан” тос ХХК-ийн ерөнхий захирал/:

-НӨАТ-ын босгыг 50 сая төгрөгт хүргэж өндөрсгөх тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэх гэж байгааг дуулаад баяртай л байна. Мөн тансаг хэрэглээний татварын хувь хэмжээг нэмэх шаардлагатай. Баян, ядуу ялгаагүй татвар төлөөд байх нь тийм ч зөв зүйл биш байх. Тиймээс татварын ялгавартай зөв бодлого, зохицуулалт хийх цаг нь болсон. Дараагийн нэг чухал зүйл бол татварын бодлогыг үйлдвэрлэгчдээ дэмжихэд

“ Татварын бодлогыг үйлдвэрлэгчдээ дэмжихэд чиглүүлмээр байна. Дэмжих гэхээр бид учиргүй татвар төлөхөө болих тухай асуудал биш юм. ”

чиглүүлмээр байна. Дэмжих гэхээр бид учиргүй татвар төлөхөө болих тухай асуудал биш юм. Адаглаад импортыг орлож байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бол ижил төрлийн бараа бүтээгдэхүүний гаалийн татварыг өндөр болгох замаар зах зээлийг нь хамгаалах гэдэг ч юм уу. Гэтэл манайд энэ талын бодлого эсэргээрээ байдаг.

М.АРИУНАА /“Монхимо” ХХК-ийн ерөнхий захирал/:

-Татвартай холбоотой асуудал олон бий. Ихэнх асуудал нь хуулиа дагаж мөрдөөгүйтэй холбоотой үүсдэг. Энгийн жишээ дурдахад Шинжлэх ухаан технологийн буюу инноваци шингэсэн төсөл хэрэгжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарим төрлийн татвараас чөлөөлөх тухай хуулийн заалт байдаг. Гэтэл энэ хуулийн заалт амьдралд хэрэгжсэн нь үгүй. Өдгөө

“ Хэрвээ шинэчлэх цаг нь болсон бол шинэчлэх л хэрэгтэй. Гэхдээ нэг хууль гаргаад тэр нь өнөөдрийнх шиг хэрэгжихгүй бол ямар ч хэрэггүй. ”

бараг мартагдах шахсан. Адаглаад хуулийн энэ заалтыг сөхөж хараад амьдралд хэрэгжүүлж чадвал шинжлэх ухаанч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төрөөс үзүүлж байгаа том дэмжлэг болно. Сүүлийн үед татварын шинэчлэл яригдаж байна. Хэрвээ шинэчлэх цаг нь болсон бол шинэчлэх л хэрэгтэй. Гэхдээ нэг хууль гаргаад тэр нь өнөөдрийнх шиг хэрэгжихгүй бол ямар ч хэрэггүй. ■



European Union



European Bank
for Reconstruction and Development



consult expo 2014

Менежмент, стратеги,
Маркетинг, хүний нөөц,
Компанийн засаглал,

Санхүү, хөрөнгө оруулалт, аудит

Программ хангамж,

Инженеринг, барилга, уул уурхай

Байгаль орчин зэрэг мэргэжлийн

чиглэлийн зөвлөх компаниуд оролцоно.

ХҮРЭЛЦЭН ИРСЭН ЗОЧДОД

ИНТЕРАКТИВ БИ АЙ ХХК-ын санхүүгийн
RUBY програм ашиглах 6 сарын эрх,

ҮЗЭСГЭЛЭН, ФОРУМ

Монголд **2** дахь удаагаа
зөвлөх үйлчилгээний **50** гаруй
байгууллагуудыг нэгтгэсэн үзэсгэлэн

V/20-21-ны өдрүүдэд

Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхим

1-р давхарын үзэсгэлэнгийн заал

Байршил: ХУД Төв цэнгэлдэх

хүрээлэнгийн зүүн талын
Жаргалан хотхоны урд

Мэргэжлийн бизнесийн зөвлөхийн
үнэ төлбөргүй зөвлөгөө гэх мэт
олон олон бэлэгтэй.



77120003, 94090929, 99051485



WWW.CONSULTEXPO.MN

ТОМИЛОЛТ

ЦОГТЦЭЦИЙГЭЭС ГАШУУНСУХАЙТ

Түрүүч нь №09 (067) дугаарт

ЦАГААН ХАДАН ДАХЬ БАРААН АМЬДРАЛ

С.БАТЗАЯА

Шороон замаар тоос татуулан машинууд зөрнө. Ар араасаа цуварсан том оврын тээврийн хэрэгслүүд урдах зам байтугай ойр орчимдоо битүү тоосон мананг бий болгох. Ойролцоох зүйлс харагдахгүй учир хүмүүс замаас холуур өнгөрөхийг бодно. Гэсэн ч өдөр бүр, цаг тутамд ийм дүр зураг давтагддаг учир эндхийн хүмүүс хэдийнэ дасан зохицжээ. Уул уурхайг дагасан их нүүдэл, амьдрал ахуйгаа дээшлүүлэх гэсэн хүмүүсийн хөл хөдөлгөөн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Цагаан хаданд бий болсон учраас амьдрал ийн өрнөнө. Хэдхэн жилийн өмнө өмнийн говийн аглаг тал байсан энэ газарт Гаалийн хяналтын бүс байгуулагдсанаар бүх зүйл орвонгоороо өөрчлөгдсөн байна. Цогтцэций сумын нутагт байрлах “Эрдэнэс Тавантолгой”, орон нутгийн өмчит жижиг “Тавантолгой”, “Ухаахудаг” нүүрсний уурхайгаас тус газар 240 орчим км-ын зайтай. Уурхайгаас ачсан нүүрсийг энд буулган шилжүүлэн ачиж, экспортолдог.

Өдөр шөнөгүй нүүрс тээврийн машинууд хөлхилддөг учраас тоос шороо, хөө тортог дийлдэхгүй. Тиймээс Цагаан хаданд цагаан бүрээстэй айл гэж үгүй. Хөдөө нутагт хун цагаан гэр холоос тодордог байтал энд бөөрөнхий хар зүйлс л харагдах. Монгол орны өнцөг булан бүрээс амьдрал ахуйгаа дээшлүүлэхээр хүмүүс ирж суурьшин, бяцхан суурин газар бий болгожээ. Гэрүүдийн бүрээс салхи шуурганд урагдаж, гэрийн мод нь нэг тал руугаа далийж, хэзээ мөдгүй нурж унахад бэлэн болчихож. Энэ газар сумын төвөөсөө 130 км-ын зайтай. Хүн ам олноор суурьшиж буй учраас баг байгуулсан ч удирдлагууд нь сумын төв дээрээ суудаг учир бараг үзэгддэггүй гэнэ. Үүнээс ч болсон уу эндхийн айлууд ямар ч эмх цэгцгүй юм. Хаа тааралдсан газраа гэр барьж, түүнийгээ тойруулан есөн шидийн зүйл овоолжээ. Эвдэрч хэмхэрсэн машины сэг, дугуй, ▶



ХҮРТЭЛХ СААРАЛ АМЬДРАЛ-3



Цагаан хадан дахь дүр зураг

▸ ундуй сундуй эд хогшил хөглөрөх. Эндхийн иргэдийн аж амьдралыг харуулсан дэлгэрэнгүй сурвалжлагыг дараагийн дугаартаа нийтлэх тул ингэсхийгээд түр азная.

Цагаан хаданд нэлээд олон уурхайн агуулах байдаг учир урд хөрш рүү нүүрс гаргахгүй байсан ч хөө тортог дийлдэггүй байна. Учир нь, уурхайгаас олборлосон нүүрсээ экспортлох зорилгоор компаниуд Гаалийн хяналтын бүс дэх агуулахдаа буулгаж, хураадаг аж. Тиймээс агаар дахь тоос шороо замхарсан ч төд удалгүй дахиад л байдал давтагдана. Уул уурхай түр зогссон гурван сард ч Цагаан хаданд байдал хэвээр байсан гэнэ.

Нүүрс тээврийн машинууд 70 тонн-ын даацтай. Гэсэн ч компаниуд болон хөлсний жолооч нар ашиг орлогоо бодон 100 гаруй тонн-ыг ачдаг байна. Үүнээс болж осол их гардаг учир миний бие нүүрс тээврийн машинд сууж, сурвалжлага хийж явахдаа багагүй айдастай байв. Машины цонхоор урдах зам бүдэг бадаг харагдана. Урд талд яваа ачаатай болон хажуугаар зөрөх хоосон машинууд хэд гурваараа өнгөрвөл хэсэгтээ л зам харагдахгүй. Ийм үед жолооч нар хурдаа сааруулах бөгөөд зам харагдтал хүлээж зогсоно гэсэн ойлголт байдаггүй аж. Яагаад гэвэл энд цаг минут бүр үнэтэй. Гэхдээ намайг сурвалжлагаар ажиллах үед нүүрсний экспорт харьцангуй бага байсан үе гэнэ. Оргил ачаалалтай үед өдөрт 1000 машин хилээр нэвтэрдэг бол харин өнгөрсөн сарын дундуур дөнгөж 400 гаруйхан байв. Гэсэн ч урдах зам бүдгэрээд ирэнгүүт л өөрийн эрхгүй айдаст автдаг юм билээ. Машинаас буугаад харвал, өмсч явсан хувцас тас хар болсон байв. Цаг тутамд манарч байдаг тоос шороо, хөө тортог машин дотор хуруу зузаан тогтсон нь хувцсанд маань наалдаж, толбо үлдээсэн нь энэ аж.

“Янхан” жолооч нарын ирээдүй үнэхээр бүрхэг

Цагаан хаднаас Гашуунсухайтын боомт хүртэл 25 орчим км. Энэ хэсэгт явж буй машинууд богинын тээвэр хийдэг учраас ихэнх нь шороон замаар явдаг байна. Тэгсэн хэр нь хоёр машин зөрөх шороон зам нь нарийхан. Харин үүнийг жолооч нар тоодоггүй аж. Үүнийгээ яваад сурчихсан учраас гайгүй байдаг юм гэж тайлбарлах. Уурхайгаас Хятадын Ганцмодны боомт хүртэл нүүрс тээвэрлэдэг хоёр төрлийн жолооч байдаг аж. Нэгдэх нь дотоодын компаниудын бол хоёрдахь нь сайн дураараа ахиу мөнгө олохын тулд хятадуудын машиныг барьдаг хөлсний жолооч нар юм. Хоёр дахь хэсгийнхэн ямар нэгэн даатгалд хамрагдаагүй. Амь насаа өөрсдөө хариуцахаар дэнчин тавьсан хүмүүс. Тэднийг “янхан” жолооч гэж нэрлэдэг ажээ. Яагаад гэвэл хөлсөөр ажилладаг учраас. ▸

▶ Тэд Ганцмодны боомтод нүүрсээ буулгаад буцахдаа 280 мянган төгрөг авдаг байна. Хариуцлага, эрсдэл өндөртэй ч сайн ажиллабал их мөнгө олно гэсэн зарчим баримталж, өдөр шөнөгүй зүтгэдэг гэх. Сард 10 удаа богинын тээвэр хийвэл 2.8 сая төгрөгийн цалин авах учир жолооч нар мөнгө бодож ажилладаг гэсэн. Гэтэл нүүрсний экспорт өмнөх жилүүдтэй харьцуулахад муудсан учир тэд долоо хоногт нэг удаа тээвэр хийж буй аж. Нийгмийн даатгал төлөхгүй, том оврын хүнд даацын машин жолоодох үнэмлэхтэй байхад л болдог гэнэ. Тиймээс Монгол орны өнцөг булан бүрт буй хүмүүс нэг нэгнээсээ ам дамжин сонссоор Цагаан хаданд л амьдрал байна гэж иржээ. Үнэмлэхээ бариад хил нэвтрэн тэнд нүүрс ачуулахаар зогсч буй хятадуудын машиныг унаж, орж ирдэг байна. Тэд манай нүүрсний компаниудтай гэрээ хийсэн байдаг аж.

Хятадууд хүнд даацын 8000 машинтай. Үүний 4000-ыг нь монголчууд жолоодож, нүүрс зөөдөг байна. Машин жолоодох эрхийг нэг хүн жилд 1500 юанийн хураамж төлж, Хятадын компаниас авдаг. Урт, богинын тээвэрт явахаа тухайн үедээ хятадуудтайгаа ярьж байгаад шийддэг аж. Цагаан хаданд нүүрс тээврийн дотоодын компаниудын жолооч маш цөөхөн. Ихэнх нь хөлсний жолооч учраас ийм нэртэй болжээ. Энд эмэгтэй жолооч хүртэл бий гэсэн. 110-аас дээш тонн нүүрс ачиж ирсэн тохиолдолд хятадууд нэмж 100 юанийн урамшуулал жолоочдоо өгдөг юм байна. Энэ талаар хөлсний жолооч н.Дашдаваа “Хятадууд монголчуудыг сайн дураараа ажиллуулдаг юм. Уг нь тэд өөрсдөө нүүрсний тээвэрт явдаг. Визнийх нь хугацаа дуусчихаар биднийг богинын тээвэрт явуулдаг” гэв.

Миний суусан машин 118 тонн нүүрс ачжээ. Даац хэтрүүлж ачсанаас машины чиргүүл тасарч, хоорондоо мөргөлдөх тохиолдол их аж. Гэсэн ч жолооч нар амь биеэ үл хайрлан хятадуудын урамшуулал болгож өгдөг 100 юанийг авахын тулд ийн ажиллаж байна. 100 гаруй тонн нүүрс ачсан машинууд заримдаа тоормоз нь ажиллахгүй болчихдог гэнэ. Энэ мэт шалтгаанаас болж осол гарч байна. Жолоочийн буруугаас машин эвдэрвэл тэд л өрөнд унадаг. н.Дашдаваа Цагаан хаданд ирээд гурван сар гаруй болж буй аж. Хөвсгөлөөс энд л амьдрал байна гэж зорьж иржээ. Одоохондоо мөнгө хуримтлуулж амжаагүй хэмээн ярих. “Янхан” жолооч нар нүүрс тээвэрлүүлэх машин олтол Хятадын буудалд байрладаг юм байна. Ганцмодны боомтод буудал хоног нь 70-100 юань. Энэ мөнгөө өөрсдөө гаргана. Сүүлийн үед Хятадууд цалингаа гүйцэд өгөхгүй байгаа гэнэ. Тэдний машинаар нүүрс тээвэрлэхээр гарахад урьдчилгаа 300-400 юанийн хамт машинд нь 100 литр

түлш хийж өгдөг. Монголын талд явж байгаад түлш дуусвал жолооч нар өөрсдөө хариуцдаг байна. Нүүрсний үнэ зах зээл дээр муу байгаа учраас одоогоор Хятадын Ганцмодны боомтод нүүрс овоороод байгаа аж.

Дугуй засвар хамгийн ашигтай

Нүүрс тээврийн машинуудын дугуй хагарах тохиолдолд хамгийн түгээмэл. Тиймээс Цагаан хаданд 5-6 дугуй засвар байдаг аж. Нэг дугуй нөхөхөд 10, илүү дугуйг нь солиход найман мянган төгрөгийн үнэтэй. Нүүрсний экспорт эрчимтэй байх үед дугуй засвар ажиллуулдаг хүн өдөрт дунджаар 150-200 мянган төгрөг олдог байжээ. Харин одоо орлого нь хумигдаад байгаа гэсэн. Орхон аймгаас нүүж ирэн гэр бүлээрээ дугуй засвар ажиллуулж буй н.Оюунцэцэг “Манайх гурван хүүхэдтэй. Том нь оюутан. Дугуй засвар ажиллуулахын зэрэгцээ гэрээрээ

хоол хийж зардаг. Энд удаан амьдарвал эрүүл мэндээ алдах юм билээ. Тиймээс нэг их удаан амьдрахгүй л гэж боддог юм. Нүүр нүдгүй шуурах нь үнэхээр хэцүү. Ирснийхээ дараа буцах бодол ч төрсөн. Сар гаруй болоод дасдаг юм билээ. Өмнө нь цалин харж амьдардаг байсан. Гэтэл өөрийн гэсэн орлоготой болоод ирэхээр тэсээд ажиллаж гэж бодогдсон” хэмээв. Эднийх хүүхдээ сургуулиа төгсөхөөр Орхон аймагт очиж хувиараа хөдөлмөр эрхлэх

бодолтой байгаа аж.

Боомтоос Цагаанхадан дахь Гаалийн хяналтын бүс хүртэл нүүрс тээвэрлээд хоосон ирэхдээ засмал замаар явбал 100 юанийн төлбөр төлдөг. Энэ мөнгийг жолооч нар өөрсдийнхөө халааснаас гаргадаг учраас шороон замаар явдаг байна. Эмнэлгийн үйлчилгээ энд байхгүй. Багийн эмч байдаг ч сумын төв дээрээ суудаг аж. Энэ талаар н.Оюунцэцэг “Ийм их шороо тоос, агаарын бохирдол амьсгалын замын эрхтэнд нөлөөлж байгааг үгүйсгэхгүй. Бид залуу хүмүүс болохоор одоохондоо анзаарахгүй байх шиг байна. Эмнэлэгт хандахаар бол бид хамгийн багадаа 130 гаруй км явж Ханбогд сумын төв орж тусламж үйлчилгээ авах боломжтой. Хааяа толгой, гэдэс дотор өвдөхөд өвчин намдаах эм уугаад аргалдаг. Эндхийн бүх хүн тийм. Сум явах машин тэрэг ч цөөхөн. Замын унаанд дайгдаад биеэ үзүүлэхээр явах хүн тун ховор доо” гэв.

Хөвсгөл, Булган, Эрдэнэт, Увс, Ховд, Завхан гээд бүх аймгаас хүмүүс ирж энд суурьшжээ. Нэгэнт хүн ам төвлөрсөн учраас цэцэрлэг, бага сургуультай болохыг тэндхийн иргэд хүсч байсан. Түүнчлэн төрөөс том оврын машины жолооч нарыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, засмал замаар явуулах нь хүн ардынхаа амь нас, эрүүл мэндийг тодорхой хэмжээнд хамгаалж буйн илрэл болох биз ээ. Тиймээс энэ асуудалд төрийн бодлого үгүйлэгдэж байгааг түшээдэд сануулах нь зүйтэй болов уу. ■

Үргэлжлэл бий.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ИРЭЭДҮЙГ ГЭРЭЛТҮҮЛЭХ “МӨРӨӨДӨЛ” ЦОГЦОЛБОР

С.ЗАЯА

Сумын төвийн захдуу шар, цагаан, цэнхэр өнгө хосолсон барилга байх. “Цэций” хороолол буюу “Вива сити”-тэй хаяа дэрлэн орших энэ барилга сумын хөгжил цэцэглэлтэд өнгө нэмжээ. Ойртон очвол Цогтцэций сумын VI сургууль, VII цэцэрлэг гэсэн хаяг байв. Өөдлөх айл үүднээсээ гэдэг. Тус барилгын гаднах талбайг тохижуулснаас харахад хүүхэд багачуудын сурч боловсрох, хүмүүжих орчинд ихэд анхаарсан нь нүднээ илхэн. Тоглоомын талбай, нарлах сандал зэргийг байрлуулж, тойруулан хийсэн гэрэлтүүлэг нь чамин хийцтэй аж. “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн үүдээр орвол нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн тохижилтоос ч илүү байв.



Фотог зохиогч

VI сургуулийн хичээлийн танхим



Олон улсын жишиг стандартад нийцсэн “Мөрөөдөл” цогцолборыг Өмнөговь аймгийн ЗДТГ болон “Энержи ресурс” компанийн хамтын хөрөнгө оруулалтаар байгуулсан нь энэ аж. “Энержи ресурс” компанийн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 5.1 тэрбум төгрөг гаргасан бол Өмнөговьчууд 3.1 тэрбумаар санхүүжилт хийсэн байна. Тус компани сургуулийн дотоод тохижилт, тоног төхөөрөмжийн хэрэгслийн хөрөнгө оруулалтыг бүрэн санхүүжүүлжээ. Өнгөрсөн оны нэгдүгээр сарын 24-нд нээлтээ хийсэн эл цогцолбор 700 хүүхдийн суудалтай сургууль, 144 хүүхдийн багтаамжтай цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байртай аж. “Орчлон” сургуулийн сургалтын стандарт нэвтрүүлж, англи хэлийг эх хэлний түвшинд эзэмшүүлэх ▶

▶ хөтөлбөртэй гэнэ. Энэ бүхэн нь хөдөө орон нутагт боловсролын чанар, хүртээмж харьцангуй сул байдаг гэсэн ойлголтыг маань бут цохив.

Цэцийгийн багачууд хотын соёлоос хоцрохгүй

Хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс VI сургууль нэг давхрынхаа танхимийг тохижуулжээ. Энд урлагийн үзлэг болон бусад арга хэмжээ зохион байгуулдаг гэсэн. Спорт заал, танхим, номын сан нь сурагчдын хичээл хийх бүхий л орчинг бүрдүүлжээ. 75 хүний суудалтай номын сантайн дээр англи хэлний онлайн сургалт явуулах хоёр анги, мэдээлэл зүй, байгалийн ухааны иж бүрэн тоногдосон танхимтай аж. Техникийн кабинет нь охид, хөвгүүдийн насны онцлогт таарсан үйл мэтгэх, мужаан хийх боломжийг бүрдүүлсэн техник хэрэгсэлтэй юм. “Цэций” хороолол баригдсантай холбогдуулан залуу гэр бүл олноор ирж, суурьшсан учраас бага ангийн сурагч харьцангуй олон аж.

Тус сургуулийн сургалтын менежер М.Уранчимэг “Одоогоор манайх 620 гаруй сурагч, 70 гаруй ажилтантай. Сум орон нутгийн хэмжээнд харьяаныхаа хүүхдүүдийг авахаар тогтоож өгсөн. Энэ дагуу сурагчдаа авдаг. Нэг ээлжээр хичээллэдэг



Цэцэрлэгийнхээ ангиудыг монгол гэр хэлбэрээр тохижуулжээ.

учраас үдээс хойш хичээлээс гадуур сургалт, дугуйланд сурагчдаа байнга хамруулдаг. Энэ бүхэн “Энержи ресурс” компанийн хойч үедээ зориулсан маш том хөрөнгө оруулалт юм” гэв. Сумын хэмжээнд сургуулийн насны 1500 орчим, цэцэрлэгийн насны 700 гаруй хүүхэд байжээ. Тэд нэг сургууль, цэцэрлэгт багтах боломжгүй байсныг шинээр цогцолбор барьж өгснөөр сурч боловсрох боломжийг нь ийн бүрдүүлсэн байна.

Харин Цогтцэций сумын VII цэцэрлэгийн үүдээр оронгуут ан амьтан, цэцэг ногоон байгууламж,

усан оргилуур бүхий талбай угтав. Хүүхэд багачуудад багаас нь байгаль дэлхий, ан амьтнаа хайрлах үрийг суулгах зорилгоор цэцэрлэгийн орчинг ийн тохижуулжээ. Мөн тэд дэлхийн жишигт нийцсэн орчин, тохижилтыг бий болгох зорилго өвөртөлж. Энэ хүрээнд хүүхэд тоглож байх явцдаа олон зүйлийг туршин, танин мэдэж, хөгжсөн ёстой гэж үзсэн байна. Тиймээс сэдэвт үйл явдлын тоглоомуудыг олноор хийж, байгуулсан аж. Хамгийн гол нь хүүхэд чөлөөтэй тоглох орчныг бүрдүүлсэн нь бусдаас онцлог байв.

Монгол ахуй соёлыг цэцэрлэгийн наснаас таниулах нь чухал гэдгийг цэцэрлэгийн удирдлагууд онцолсон. Тиймээс насных нь онцлогт тааруулан анги бүрийг тохижуулжээ. Монгол гэр хэлбэрээр тохижуулсан анги ч байсан. Багачууд чөлөөт цагаа өнгөрүүлэх танхимд суманд үйл ажиллагаа явуулдаг сургууль, эмнэлэг, цагдаагийн газар, эмийн сан, банк зэрэг байгууллагыг модоор хийж, тавьсан байв. Тэд тоглох явцдаа нийгмийн амьдралд оролцож, танин мэдэх боломжтой гэж үзсэн байна. Тус цэцэрлэгийн эрхлэгч Б.Оюунгэрэл “Манайх өнгөрсөн оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Одоогоор 317 хүүхэд суралцаж байна. Хэдийгээр 150 хүүхдийн багтаамжтай ч гаднах талбайдаа гэр цэцэрлэг ажиллуулж байгаа. Мөн цэцэрлэг дотроо хоёр анги шинээр тохижуулж, ▶





Сурагчдын дотуур байр

► хүүхдүүд хүлээн авсан. “Энержи ресурс” компани манайд нэлээдгүй хөрөнгө оруулалт хийсэн. Нэг анги 35 хүүхэдтэй” гэв.

Эднийх БШУЯ-ны дэргэдэх түшиц цэцэрлэг болон ажиллаж буй аж. Энэ нь бусад цэцэрлэгээс илүү өндөр түвшинд ажиллах шаардлага бий болгосон гэнэ.

Орон нутгийн хөгжилд 10 гаруй тэрбум төгрөг зарцуулжээ

“Энержи ресурс” компани 2009 онд анх үйл ажиллагаагаа эхлэхдээ 13, 2010 онд 54, 2011 онд 116.5, 2012 онд 163.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ. Харин өнгөрсөн он дан ганц нүүрсний гэлтгүй уул уурхайн салбарын хувьд амаргүй, хүндхэн жил байсан ч тэд 52 тэрбум төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлсэн байна. Тус компани нийгмийн хариуцлага гэх ойлголтыг хандив, тусламж болон богино хугацааны төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зэрэг хязгаарлагдмал хүрээнд авч үздэггүй аж. Олон улсын болон Монголын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, улс орны эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах замаар тогтвортой

хөгжлийг бий болгохыг зорьдог гэнэ.

Тэдний орон нутагт оруулж буй хөрөнгө оруулалт бүс нутгийн хөгжлийг дэмжиж, цаашлаад орон нутгийн иргэд төдийгүй компанид ч үр өгөөжөө өгөх зорилготой аж. Энэ хүрээнд тэд өнгөрсөн онд нийт 12.2 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжилд зарцуулжээ

Мөн орон нутгийн дэд бүтцийн хөгжилд хувь нэмэр оруулахаар “Цэций” орон сууцны хороолол, “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэг, дотуур байрны цогцолбор зэргийг барьж байгуулахын зэрэгцээ,

Ухаахудаг төслийн дэд бүтцийг шийдвэрлэх хүрээнд орон нутгийн иргэдийг найдвартай эрчим хүч болон цэвэршүүлсэн ундны усаар хангаж эхэлжээ.

Орон сууцны “Цэций” хорооллыг барих хүрээнд одоогоор нийт 600 айлын есөн орон сууц ашиглалтад ороод буй. Бүрэн тавилгатай, тохилог орон сууц нь компанийн ажиллагсад болон сумын иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрэн хангасан гэх. Энэ талаар тус хорооллын оршин суугч Г.Ханд “Ачаа харахаар энд ирсэн. Хүү, бэр хоёр маань “Энержи ресурс” компанид ажилладаг юм. Залуучууд энд олноор ирж суурьших болсон. Нийгмийн асуудлыг нь шийдэж өгсөн болохоор нийслэлд амьдарч байгаагаас дутахааргүй сайхан юм. Уурхай дагасан тогтвор суурьшил бий болж, хөдөөгөөс хот руу чиглэх урсгал ч саарах байх” хэмээн ярьсан.

“Энержи ресурс” компани 2009 оноос хойш Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаахудаг коксжих нүүрсний ордод үйл ажиллагаа явуулж буй юм. Уул уурхайн олборлолт сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд аж төрөх эрхэнд тодорхой хэмжээгээр “халдаж” буй ч тэд компанийн нийгмийн хариуцлагыг олон улсын түвшинд хэрэгжүүлэн үлгэр дууриалал болж байгааг энд тэмдэглэх хэрэгтэй байх. ■



VII цэцэрлэгийн гаднах тоглоомын талбай

ҮЗЭЛ БОДОЛ

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ТОХИРОМЖТОЙ ЦАГ



С.ДЭМБЭРЭЛ /УИХ-ын гишүүн, МУХАУТ-ын дарга/

Танхим татварын талаар иж бүрэн шинэчлэл хийх шаардлагатай гэж үзэж байгаагаа илэрхийлсэн. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт татварын шинэчлэлийн хоёр дахь үе шатыг эхлүүлэх заалт бий. Үүнтэй холбоотой Засгийн газраас Нэмэгдсэн өртгийн албан татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн төслийг УИХ-д оруулж байгаа. Нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг 50 сая төгрөг болгох, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг буцаан олгох зэрэг Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд дээрх хуулийн төслүүд УИХ-д орж ирж байна. Мөн МАН-ын бүлгийн ахлагч С.Бямбацогт болон бусад гишүүн нийлээд Нэмэгдсэн өртгийн албан татварын босгийн хувь хэмжээг 200 сая төгрөг болгох тухай хуулийн төсөл, түүнчлэн өнгөрсөн жилүүдэд Ерөнхийлөгчөөс өргөн барьсан хуулийн төсөл, татварын талаарх судалгаанууд бий бөгөөд дээрх саналуудыг УИХ-аас томилогдсон Ажлын хэсэг судалж үзээд Татварын иж бүрэн шинэчлэлийг хэрхэн хийх талаар санал санаачилга, нэг шийдэлд хүрэх ёстой.

Монгол Улсын өнөөдрийн байдлыг харахаар татварын иж бүрэн шинэчлэлийг хийх цаг ирсэн байна. Зөвхөн Нэмэгдсэн өртгийн албан

татвар, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараар зогсохгүй Хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ажил олгогчийн зүгээс төлж буй шимтгэлийн хэмжээ, татварын ерөнхий хууль, татвартай холбоотой бусад хууль тогтоомж, татварын хяналт шалгалтыг бүрэн хэмжээнд авч хэлэлцсэн шинэчлэл хэрэгтэй юм. Хоёрдугаарт, улс орнуудын татварын шинэчлэл хийсэн туршлагыг харахад татвар төлөгчдийн эерэг авир төрхийг бий болгох талаас нь анхаардаг. Олон орны жишээнээс үзвэл татвар төлөгчдийн татвар төлөхөөс зугтаадаг, хоёр баланс гаргадаг авир төрхийг өөрчилж татварын газартай түншилж, эрх тэгш харилцаа үүсгэхийг иж бүрэн шинэчлэл гэж хэлээд байгаа юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд татварийн ерөнхий хууль болон бүх хуулийг хөндөх болно. Харин эдгээр дээр нэмж шинэ хууль батлахгүй гэдгийг Ерөнхий сайд Н.Алтанхуяг тэмдэглэчихсэн. Татварын нийт хувь хэмжээгээ багасгая, Танхимын дөрвөн тавын зарчмын хувьд заавал тав биш тэг ч байж болно. Шинэчлэлийг татвар хураах, төлөхтэй холбогдсон, татвар төлөгч болон төр хоёрын хоорондын харилцааг эрх үүргийн хувьд тэнцвэржүүлэх, татвартай холбоотой маргааныг цагдаа, шүүх болголтгүй эдийн засгийн маргаан талаас нь хандаж, эдийн засгийн

хөшүүргээр татварын маргаан таслах зөвлөлийг илүү төлөөлөл сайтай болгох замаар шийдэх саналыг Танхимын зүгээс тавьж байгаа. Ажлын хэсгийн гишүүдээр дамжуулаад УИХ-ын гишүүдийн анхаарлыг энэ тал руу хандуулах болно.

УИХ-ын гишүүд бизнес эрхлэгчдийн татварын хяналт шалгалттай холбоотой зовлонг төсөөлдөг биз ээ. Энэ талын мэдээллээр Танхим хангаж байгаа. Үүнтэй холбоотой эдийн засгийн өршөөлийн тухай хууль яригдаж байна. Өөрөөр хэлбэл, татварын шинэчлэл хийсэн улс орнууд гол төлөв эдийн засаг нь болзошгүй хямралын өмнө тулсан, эдийн засгийн идэвхжил нь буурсан үед миний энэхүү тэмдэглэж буй арга барилаар хийвэл төсвийн талаасаа татварын орлогоос дутна гэж санаа зовох шаардлагагүй. Татварын орлого нэмэгддэг, суурь нь томордог. Ингэсэнээр татвар төлөгчид татвараа шударга төлөх, татварын байгууллага, татвар төлөгчдийн хоорондын харилцаа тэнцвэртэй болох юм. Энэ бүхнийг манай өнөөдрийн эдийн засгийн бодит байдал шаардаж байна. Монгол Улсын эдийн засаг хоёр хуваагдчихжээ. Албан, албан бус сектор гэж. Албан бус сектор нь сүүдрийн эдийн засаг, сүүдрийн сектортой болсон. Хамгийн даруу тооцоогоор нэг их наядын эдийн ▶

► засаг, ДНБ-ий гуравны нэгтэй тэнцэх хэмжээний албан бус эдийн засаг байна. Сүүлийн үед татварын орчин нэмэгдсэнтэй холбоотой томоохон компаниуд гадагшаа татвараас зугтах, офшор данс ашиглах, жижиг, дунд компаниуд нь албан бус секторт орох, компаниа жижигрүүлэх хандлагатай болсон. Татварын босгыг нэмэгдүүлэх нь ийм хор уршигтай. Тийм учраас бүгдээрээ төлье, бага хувиар төлье, татварын төлөх үйл явцыг хялбаршуулъя, татварын байгууллагатай эрх тэгш харилцах нөхцөлийг бүрдүүлж, татварын маргааныг хоёр талаасаа харилцан ярилцдаг, хөндлөнгийн хүмүүс оролцож шийддэг механизмтай болъё гэсэн ерөнхий уур амьсгал нийгэмд яваад байна. Энэ уур амьсгалыг зөв мэдрээд УИХ татварын шинэчлэлийг хийх хэрэгтэй.

Татварыг жигд хувьтай болгосноор онолын хувьд олон янзаар ярьдаг. Жишээлбэл, орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлнэ гэх ч юм уу. Гэтэл олон ялгавартай тогтоох нь харин ч илүү орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлэх талтай байдаг. Манай судалгаанд бий. Татварын flat буюу жигд татвар. Дотроо өөрөө уян хатан байж болно. Жишээлбэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр уян хатах байх боломжтой.

Монгол Улс татварын ачаалал багатай орон. Харахад бол тийм. Өөрөөр хэлбэл, дөрвөн арав гэхэд 40 хувь. Дээр нь 10 хувийг бусад улсад 20, 30, 40 хувь байдаг. Гэтэл тийм биш гэдгийг батлах хоёр шалтгаан байна. Нэгдүгээрт, дөрвөн арав дээр олон төрлийн татвар нэмэгддэг. Энэ бүхэн нийлээд татварын ачааллыг нэмэгдүүлж байна. Мөн татвар хураах, хяналт шалгалт явуулах нь асар их дарамттай ажил болсон. Энэ нь мөнгөн дүнгээр илэрхийлэгдэхгүй, цаг хугацаа тэр байтугай хүний эрх чөлөөнд нөлөөлж байна. Татварын хяналт шалгалтад алданги, торгууль, хүү тооцож байна. Мөн олон компанийн асуудлыг цагдаа эрүүгийн байдлаар шийдэж энэ нь цаашлаад цагдаа, шүүх маягийн татварын хэв шинжтэй болж. Энэ нь хүмүүсийг ч татвараас зугтаахад хүргэх төдийгүй авлига өгөх нөхцөлийг бүрдүүлж байна. Шоронд орохгүйн тулд хүн яаж ийж байгаад аргалж таарна.

Энэ бүхнийг эрүүлжүүлэх хэрэгтэй. Түүнээс учиргүй ялгавартай татварын систем, ялгаваргүй нэгдсэн татварын системд орохдоо гол нь биш. Тухайлбал, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 100 хувь байхгүй боллоо гэж бодъё. Монгол Улс сөнөх үү. Аж ахуйн нэгжүүд орлогын албан татварт өгдөг мөнгөө эдийн засгийн, нийгмийн төсөл хөтөлбөрт зарцуулаад эхэлбэл тэрийг нь дэмжих хөшүүрэг бий болговол улсын төсвийн ачаалал багасна. Мэдээж хэрэг нийгмийн олон зорилт бий. Бааз сууриа нэмэгдүүлбэл нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх боломж гарч ирнэ.

Бидний нууж чаддаггүй, бүгд мэддэг нэг зүйл бол бүх байгууллага хоёр баланстай байдаг. Төрийн буруу бодлогын үр дүнд гарч ирсэн үзэгдэл. Ийм учраас энэ бүх асуудлыг арилгах, бүгдээрээ бага хувь хэмжээгээр

шударгаар татвараа төлдөг байх. Ингэснээр улсын төсвийн орлого нэмэгдэж, төсвөөс гарах халамж, тэтгэвэр тэтгэмжийн тогтолцоо нь өөрөө эдийн засагжиж байдаг. Иймэрхүү тогтолцоо руу орохгүй бол болохоо байсан байна. Татварын хяналт шалгалт байж болно. Гэхдээ давхарддаггүй, дарамтгүй байх хэрэгтэй. Компаниудын өнгөрсөн алдааг сөхөж заавал нэг алдааг олж авах гэж зүтгэдэг, түүн дээр нь торгууль алданги, хүү тооцдог, татварын байцаагчид нь дуудаж хүрээд ир гэж дээрэнгүй зангаар харьцдаг тэгш бус харьцаа, дарамтыг болих хэрэгтэй байна. Тийм учраас татварын бүрэн шинэчлэл нь зөвхөн хувь хэмжээ, босгын асуудал биш, бүх талаасаа сайн бодсон татварын харилцааг бүхэлд нь хамарсан иж бүрэн шинэчлэл хийх шаардлагатай байгаа юм. Үүнийг хийх тохиромжтой цаг нь яг одоо буюу 2014 он юм. ■

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХӨРӨНГИЙН БИРЖЭД ХӨЛ УРГАСАН УУ



Б.ТОГТОХ

Шинэчлэл үргэлжилнэ

Монголын хөрөнгийн биржийн шинэчлэлийн өртөг нь нийт 13.4 сая ам.доллар. Үүний 80 хүртэлх хувь нь хөрөнгийн биржийн шинэчлэлд, үлдэж буй нь үйл ажиллагааны бусад зардлыг санхүүжүүлсэн. Өөрөөр хэлбэл, хамгийн хурдан арилжааны системтэй болох гэж манайх Лондоны хөрөнгийн биржийн багтай гурван жилийн хугацаанд хамтран ажилласан. Энэ хугацаанд “Миллениум Ай Ти” системийг суурилуулсан, Үнэт цаасны тухай хууль шинээр мэндэлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдлаа.

Үнэт цаасны тухай хуулийн төслийг боловсруулахын тулд Лондоны ►

▶ менежментийн баг 30 мянган ам.доллараар гадаадаас хуульч хөлсөлж авсан байдаг. Зөвхөн техникийн шинэчлэлээр зогсохгүй эрх зүй орчинд ч шинэчлэл зайлшгүй шаардлагатай байсан нь энэ. Шинээр гарсан эдгээр хуультай нийцүүлэн хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг зохицуулах 10 гаруй дүрэм, журмыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Монголын хөрөнгийн бирж /МХБ/ шинэчилжээ. Удахгүй хөрөнгийн биржийн өөрийнх нь бүртгэлийн журам гарна. Тус журмыг биржийн ТУЗ эцсийн байдлаар батлах юм.

Эдийн засгийг эрчимжүүлэх Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд МХБ-ийн үйл ажиллагаа олон улсын түвшинд хүргэнэ гэж оруулсан байгаа. Энэ талаар Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын Хөрөнгийн зах зээлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Жамбаажамц “Зээлжих зэрэглэл муудсан. Эдийн засаг амаргүй байгаа нөхцөлд хөрөнгийн зах зээл идэвхжих боломж тааруухан байгаа” гэв. Харин УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Санхүүгийн зах зээлээр дамжиж орж ирдэг хөрөнгө оруулалтыг манайх татах чиглэлд анхаарах хэрэгтэй. Монголын аж ахуйн нэгжийн хувьцааг худалдаж авах сонирхол хөрөнгө оруулагчдад байгааг үгүйсгэх аргагүй. Энэ нь санхүүгийн зах зээлд өрнөх шууд бус хөрөнгө оруулалтын нэг хэлбэр. Тиймээс шууд бус хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах. Энэ чиглэлд үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх ёстой. Жишээ нь Кастодиан банкны үйлчилгээг яаралтай нэвтрүүлэх. Үүнийг хийгээгүй нөхцөлд хөрөнгө оруулалт орж ирнэ гэж мөрөөдөөд ч хэрэггүй” хэмээсэн нь бий.

Тэгвэл үүнтэй холбоотой мэдээлэл дуулгахад Монголын дөрвөн банк /ХААН, Хас, Голомт, Худалдаа хөгжлийн банк/ Кастодиан банкны үйлчилгээг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна. Тэд эдийн засагт биет бус хөрөнгө оруулалтыг татах, зах зээлийн арилжааг илүү боловсронгуй болгохоор Монголын хөрөнгийн биржийн /МХБ/-ийн өмнө үүрэг хүлээжээ. Ийнхүү анхдагч зах зээлийн арилжаа Кастодиан банкаар явагдах аваас хоёрдогч зах зээлийн

арилжаа МХБ-ээр хийгдэх юм. Санхүүгийн зохицуулах хорооноос энэ оны эхний улиралд “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Мөн “Үнэт цаасны бүртгэлийн журам” тэргүүтэй хэд хэдэн журмыг албажуулжээ.

Тооноос чанарт

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 330 орчим компани 200 болон цөөрч, чанаржжээ. Тэд Компанийн тухай хуулийн дагуу санхүүгийн тайлангаа олон нийтэд мэдээлж байгаа аж. Мөн биржид бүртгэлтэй хэрнээ хэзээ ч хувьцаа арилжаалдаггүй компаниуд үнэлгээнд жин дардаг. Тэгвэл эдгээр компанийг хаалттай компани болгож, ҮЦТТТХТ-д

“**Монголын дөрвөн банк /ХААН, Хас, Голомт, Худалдаа хөгжлийн банк/ Кастодиан банкны үйлчилгээг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлаа хангаж байна. Тэд эдийн засагт биет бус хөрөнгө оруулалтыг татах, зах зээлийн арилжааг илүү боловсронгуй болгохоор Монголын хөрөнгийн биржийн /МХБ/-ийн өмнө үүрэг хүлээжээ.**”

бүртгүүлэх журмыг энэ сард СЗХ-ноос гаргажээ. Үүнд төрийн өмчит МИАТ тэргүүтэй компани ордог. Тэд хувьцаагаа задлах, олон нийтээс хөрөнгө татах тохиолдолд нээлттэй компани болох боломжтой. Ингэснээр хөрөнгийн зах зээлд ойртох нэг алхам болох юм. Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 3.8-д хаалттай хувьцаат компанийг “... хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Шинэ захирал, өрийн асуудал

Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал, дээрх шинэчлэлийг гардан хийсэн хүмүүсийн нэг Х.Алтай үүрэгт ажлаа хүлээлгэн өгөөд дөрвөн сар болж буй. Энэ хугацаанд биржийн дараагийн захирлын асуудлыг олон нийтэд нээлттэй байдлаар зарласан. Тэгвэл энэ долоо хоногт /2014 оны дөрөвдүгээр сарын 12-ноос 19/ хөрөнгийн биржийн үйл ажиллагааг удирдах шинэ захирал тодрох юм. Одоогоор Монголын хөрөнгийн биржийн захирлын үүрэг гүйцэтгэгчээр Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн удирдлагын газрын дарга Д.Болормаа ажиллаж байгаа билээ.

“Ажлын мастер гэрээ”-гээр хүлээсэн үүргээ Лондоны хөрөнгийн бирж гүйцэтгэсэн. Харин манай Засгийн газар хийсэн ажлынх нь төлбөрийн асуудлыг шийдэхгүй явсаар гэрээ дууссан хойно буюу энэ сарын 10-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар Лондоны талд 1.5 сая ам.долларыг шилжүүлэхээр болсныг Ерөнхий сайд мэдэгдсэн.

МХБ-ийн Лондоны хөрөнгийн биржтэй байгуулсан “Ажлын мастер гэрээ” энэ оны дөрөвдүгээр сарын 7-ны өдрөөр дуусгавар болсон. Ингэснээр Техникийн шинэчлэл бүрэн дуусаж, Лондонгийн хөрөнгийн биржийн экспертүүд ирээд дүгнэлт хийгээд буцсан байна. Шинэ системтэй болсноор МХБ-ийн арилжаа хурдан шуурхай хийгдэхээс гадна брокер дилерийн компаниуд өөрсдийн байрнаас электрон арилжаанд оролцох боломжтой болжээ. Нэг үгээр хэлбэл, манай санхүүгийн зах зээлд дэд бүтцийн болон эрх зүйн орчин бүрдсэн гэж болно. “Ажлын мастер гэрээ”-нээс гадна хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байсан. Энэ гэрээ цааш үргэлжилнэ гэдгийг МХБ-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Болормаа хэллээ.

Зуун хувийн төрийн өмчит дэлхийн хөрөнгийн биржүүдийн нэг нь манайх. Тиймээс эрт, орой хэзээ нэгэн цагт хувьчлах нь илүү оновчтой хэмээн үзэх хэсэг ч бий. Ингэснээр илүүтэй ашигтай ажиллах төдийгүй хөгжих бололцоо байгааг онцлох хүн цөөнгүй. ■

БОНД

ИРЭЭДҮЙГЭЭС ЗЭЭЛСЭН ӨРИЙН ЗАРЦУУЛАЛТАЙ ТАНИЛЦ

С.ЗАЯА

Манай улс эзэн Чингис хаанаараа овоглосон өрийн бичиг гаргаж, дэлхийн зах зээл дээр амжилттай арилжаалсан. Харин энэ мөнгөө үр өгөөж муутай төсөл хөтөлбөрт зарцуулж буй нь эргээд өрөө хэрхэн төлөх вэ гэх асуудал үүсэхэд хүргэсэн. Учир нь, бондын хөрөнгө болох 1.5 тэрбум ам.долларын эхний 500 сая ам.долларыг 2018 онд үлдсэнийг нь 2022 онд төлнө. Эхний таван жилд бид зөвхөн хүүнд 71.9 сая ам.доллар төлөх юм. Мөн Хөгжлийн банкнаас гаргасан 580 сая ам.долларыг 2017 онд төлөх учир ирээдүйн төсөвт ирэх ачаалал, дарамтыг багасгах шаардлага үүсээд буй. Хамгийн гол нь, эдгээр өрийг ямар эх үүсвэрээс гаргах нь тодорхойгүй байгаа. Тиймээс энэ оны төсвийн тодотгол хийх үеэр дээрх өрийн гуравны нэгийг нь бүрдүүлэх эх үүсвэрийг тусгаж, нөөц сантай болох ёстойг УИХ дахь сөрөг хүчнийхэн хэлж байна.

“Чингис” бондын хөрөнгийг нийт хэдэн аж ахуйн нэгжид олгосон, үлдэгдэл хөрөнгийг ямар банкуудад хэдэн хувийн хүүтэй хадгалсан нь олон нийтэд ил тод бус байгаа. Ерөнхий сайд Н.Алтанхуяг бондын хөрөнгөөр хийж буй ажлаа танилцуулсан ч дээрх мэдээлэл мөн л бүрхэг хэвээр үлдэв. Ямартай ч бондын үлдэгдэл нэг их наяд 267.2 тэрбум төгрөг байгаа гэнэ. Үүнээс 394 тэрбум төгрөгийг импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх төсөлд зарцуулахаар төлөвлөжээ. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж бондын зарцуулалтыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд албан ёсоор танилцуулахыг Засгийн газарт

үүрэг болгосон. Ингэхдээ бондын хөрөнгөөр Монгол Улсын эдийн засгийн бие даасан болон аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг тэргүүн эгнээнд санхүүжүүлсэн эсэхийг шалгах юм.

Төмөр замын төслийн санхүүжилт сох дутаг

Гүйцэтгэх засаглалын тэргүүний өгсөн мэдээллээр аймгийн төвүүдийг холбох ажилд 2013 онд шинээр хэрэгжих 10, он дамжин хэрэгжиж буй 14 зам барилгын ажил болон хяналтын зөвлөх үйлчилгээнд 570 хүртэл тэрбум төгрөгийг “Чингис” бондын хөрөнгөөс санхүүжүүлэхээр болжээ. Одоогоор Дундговь, Баянхонгор аймгийг нийслэлтэй холбоод байгаа аж. Харин “Гудамж” төслийн хүрээнд Туул, Сэлбэ голын дагуу хурдны зам барьж, 33 уулзварыг


шинэчлэх, гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах ажил хийж буй. Үүнээс 16 уулзвар, хоёр автозамыг ашиглалтад оруулсан аж. Нийслэлийн

инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг сайжруулахад нийт 416.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 92 төслийг 2013, 2014 онд хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнээс Хөгжлийн банк эхний ээлжинд эх үүсвэр нь тодорхой 200 тэрбум хүртэлх төгрөгийг нийт 66 төсөлд олгохоор болжээ.

Тавантолгойгоос Гашуунсухайт чиглэлд 1800 км шинэ төмөр зам барихаар болсон. Уг төслийн санхүүжилтэд “Чингис” бондын хөрөнгөөс 200 сая ам.доллар олгохоор төлөвлөсөн ч 164.2 сая ам.долларыг Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замд зориулж олгосон гэдгийг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр хэлсэн. Харин Зам тээврийн сайд А.Гансүх “Тийм их хэмжээний санхүүжилт ▶



Тавантолгой, Эгийн голын төслийн санхүүжилт



► аваагүй. Шинэ төмөр зам төсөлд 20 гаруй сая ам.долларыг авсан. Үлдсэн хөрөнгийг нь яаралтай гаргуулж, ажлаа явуулах шаардлагатай” гэдгээ мэдэгдээд байгаа. Шинэчлэлийн Засгийн газрын энэ хоёр сайдын хэнийх нь үгэнд итгэх вэ. Хэрэв 20 гаруйхан сая ам.доллар өгсөн юм бол үлдсэн мөнгө нь хаачив. Энэ хөрөнгийг Хөгжлийн банк болоод “Чингис” бондын санхүүжилтээс гаргаж өгсөн, өгөөгүй тухай асуудал одоо ч маргаан дэгдээсээр байна. Үүнээс үүдэж УИХ дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлэг “Төмөр замын ажил далайцтай явж чадаагүй байх” гэсэн дүгнэлт хийжээ.

Мөн бондын хөрөнгөнөөс “Буянт-Ухаа 1” орон сууцны хорооллын төслийн хүрээнд 1764 айлын 28 барилгын ажлыг санхүүжүүлж байна. Дотоодын барилгын арматур, төмрийн хүдрийн нойтон баяжмал үйлдвэрлэх дөрвөн төсөлд санхүүжилт өгөх аж. Уг ажилд 50 сая хүртэлх ам.доллартай тэнцэх төгрөгийг “Чингис” бондын эх үүсвэрээс санхүүжүүлэхээр шийдсэн ч одоогоор 12.8 сая ам.долларыг олгожээ. Түүнчлэн ноос, ноолуур, оёмол бүтээгдэхүүн, хүлэмжийн аж ахуй, сүүний үйлдвэр байгуулахад 270 тэрбум төгрөг гаргахаар шийдвэрлэснээс өнөөдрийн байдлаар 140 орчим тэрбумыг нь ашигласан аж. Барилгын салбарыг дэмжихэд зориулж төмөрлөгийн үйлдвэрт 12.8 тэрбум төгрөг, Байшин үйлдвэрлэх комбинатад 14 сая ам.долларыг зарцуулахаар болж.

Долларын зөрүүнээс алдагдал хүлээнэ

Бонд бол ирээдүйгээс зээлсэн өр. Монголбанкны тооцоогоор Монгол Улсын нийт өр олон улсын аргачлалаар 19 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь манай улсын ДНБ-ий 170 гаруй хувьтай тэнцэж буй гэнэ. Эндээс гадаадын хөрөнгө оруулалтыг өр гэж тооцохгүйгээр хасвал 10 тэрбум ам.доллар нь манай хувийн компаниудын өр. Харин улсын өр 4.5 тэрбум орчим ам.доллар аж. 2023 онд өрөө хэрхэн төлөх нь одоогоор тодорхойгүй байна. Хэдийгээр эрх баригчид төсөл хөтөлбөрүүд тэр болтол үр өгөөжөө өгнө гэж байгаа ч яг гарт баригдахаар нь ховор гэдгийг Эдийн засагч Д.Хосбаяр хэлж байна. Тэрбээр “Бондын зарцуулалтыг анхнаасаа үр ашигтай төслүүдэд хуваарилах ёстой байсан. Нэгэнт л өр учраас богино хугацаанд үр ашгаа өгөх төслөө эхлээд санхүүжүүлэх байтал замын уулзвар, засвар, дэд бүтцэд оруулсан нь “бай”-гаа оноогүй. Үүний оронд үйлдвэрлэлийг эхнээс нь дэмжих ёстой байсан. Одооны эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор ханшийн зөрүүнээс ч алдагдал хүлээж байна” гэв.

Ам.доллараар авсан гадаад өр Монголын эдийн засагт төгрөгөөр эргэлдээд буцаад банкны системээр дамжин валют болон гардаг. Тэгэхээр ам.долларын ханшийн зөрүүнээс хохирол амсах аж. Зөвхөн өнгөрсөн жил аж ахуйн нэгжүүд зээлийн хүүний төлбөрөөс 570 орчим тэрбум төгрөгийн алдагдал хүлээжээ.

“Чингис” бондын зарцуулалтад хяналт тавих бодлогын зөвлөл гэж бий. Тэнд Эдийн засгийн хөгжлийн, Сангийн яам болон бодлого тодорхойлох төвшний газруудын удирдлагууд багтдаг аж. Чухам хэн зөвлөлд байдгийг тодорхой болгоогүйгээс бондын талаарх мэдээллийг хэнээс асуух нь ойлгомжгүй байгаа гэнэ. Мөн бондын санхүүжилт өгсөн төсөл хөтөлбөрүүд гараанаас гарсан ч гүйцэтгэл нь туйлын хангалтгүй. Төсөвт ирэх ачаалал болон өрөө хэрхэн төлөх нь таамаг төдий байсаар байна. Эргэлзээ хэзээ тайлагдаж, нэг мөр шийдэгдэх нь ч бүрхэг хэвээр. ■

МӨНГӨНИЙ БОДЛОГО

ДАРХЛААГҮЙ МОНГОЛБАНК

Б.БАЯРТГОТОХ

Улстөржүүлж болдоггүй хатуу бодлогын нэг нь мөнгөний бодлого. Үүнийг бие даасан эрх зүйн тодотголтой Төвбанк хэрэгжүүлдэг. Гэвч тусгай статустай ажиллах Монголбанкны мөнгөний бодлогыг УИХ тодорхойлж байгааг Олон улсын зэрэглэл тогтоогч “Standart and Poors” агентлаг өнгөрсөн сард гаргасан тайландаа тохиромжгүй гэж үзжээ.

Тэдний зүгээс Монгол Улсын мөнгөний бодлогын хараат бус байдал алдагдах эрсдэл өндөр байгааг өмнө нь анхааруулж байсан. Энэ удаад ч мөн адил дээрх дүгнэлтээ тайландаа тусгасан байна. Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк “Standart and Poor’s”-тэй санал нэг байгаа. Өөрөөр хэлбэл, тухайн орны зээлжих зэрэглэл тогтоох нэг хэмжүүр нь мөнгөний бодлогын бие даасан байдал аж. Тэр тусмаа бие даасан бодлого хараат бус хэрэгжих нь эдийн засаг тогтвортой хөгжих суурь “хундаам” аж.

Төвбанкны тухай хуулийн 30 дугаар зүйлд зааснаар бол “...УИХ нь Монголбанкны тайлан, танилцуулгатай танилцах бөгөөд ингэхдээ төрийн мөнгөний бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцохгүй” гэсэн байдаг юм байна. Үүгээр явбал Төвбанкны мөнгөний бодлого УИХ-ын гишүүдэд огтхон ч хамааралгүй болж таарч байгаа. Гэтэл богино зайны улстөржилт мөнгөний бодлогын тэргүүн зорилтыг няцааж, эдийн засгийн тогтвортой байдалд “гай” болох нь бий. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалт нэг жилийн хугацаанд 40 хүртэлх хувиар буурсан явдалд улстөрчдийн нөлөө орсныг үгүйсгэх аргагүй.

Мөнгөний бодлогыг Парламент нь хэлэлцэж баталдаг тогтолцоо манайхаас гадна ОХУ-д бий. Нөгөөтэйгүүр УИХ бодлого гаргах эрх бүхий төрийн дээд байгууллага. Тиймээс төрийн мөнгөний бодлогыг баталж өдгөө хүрсэн. Энэ тогтолцоо нь төдийлэн оновчтой хувилбар биш аж. Дэлхийн бусад оронд ч мөнгөний бодлогоо улс төрийн нөлөөнөөс хамгаалах гэж хичээж ирсэн нь үүнтэй холбоотой гэх. ►



► Монголбанк бол Засгийн газрын үүрэг гүйцэтгэгч агентлаг биш. Зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хадгалах үүрэг хүлээсэн эрх бүхий “мандат”-тай байгууллага. Ерөнхийлөгчийг нь зургаан жилийн томилгоотой байхаар хуульчилсан. Гэвч зургаа бус дөрвөн жилийн “нас”-тай байгаа. Энэ нь мөнгөний бодлого улс төрөөс хараат болж, түүний бие даасан байдал аль хэзээний устаж, үгүй болсныг гэрчилнэ. Нөгөөтэйгүүр баталсан хуулиа үгүйсгэж ирсэн тухайн цаг үеийн төрийн алдааг улам ч тод томруун болгох аж.

Эдийн засагт төдийгүй улс орны амьдралд тогтвортой байдал хамгийн чухал нь. Тэгвэл эдийн засгийн “энх тайван”-ны манаанд тангараг өргөсөн “цэрэг” нь Монголбанк юм. Түүний “зэмсэг” нь мөнгөний бодлого. Эдийн засагт тохиргоо хийж, инфляциас та бидний бодит орлогыг хамгаалах нь Төвбанкны тэргүүн зорилт. Үүнийг инфляцийг онилсон мөнгөний бодлого гэж нэрлэх нь бий.

СЭЗДС-ийн Эдийн засгийн онолын тэнхимийн багш Д.Түвшинжаргал “Мөнгөний бодлого бие даан оршин тогтнох, тэрхүү бодлогын үнэт зүйл хүчин төгөлдөр хэрэгжих бололцоо олохгүй байгаа” хэмээн одоогийн нөхцөл байдлыг дүгнэсэн юм. Төвбанк

арилжааны банкны санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэх болсон. Энэ нь Засгийн газрын бондыг арилжаалдаг гэсэн үг. Монголбанкны засаглал талаас аваад үзвэл уг байдал нь бие даасан бодлогод харшилж мэдэх талтайг тэрбээр тодотголоо.

Тухайн Төвбанк хэчнээн ажил хийх гэж зүтгээд эрх зүйн хамгаалалт нь сул. Томилгоо нь улс төрийн хараан дор байгаа цагт реформ хийнэ гэдэг бэрх асуудал болж хувираад байна. УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Төвбанк бие даасан мөнгөний бодлого хэрэгжүүлэх учиртай. Гэхдээ удирдлага хэн байхаас хараат бус байх нь ихээхэн хамаарч байна” хэмээсэн.

Энэ оны мөнгөний бодлого уг нь үндэсний баялаг бүтээгчдэд илүү боломж олгосон “мөрийн хөтөлбөр”-тэй. Экспортыг дэмжих, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлд боломж нээсэн стандарт бус бодлого. Гэвч засаг төрийн байдал, улс төрийн орчин, Засгийн газрын үйл ажиллагааны хурдаас мөнгөний бодлого бүрэн хэрэгжих эсэх нь шууд шалтгаалж байгааг Төвбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал учирласан нь бий. Нэг талаар мөнгөний бодлого эдийн засгийн гажгийг засна уу гэхээс асуудлыг бүхэлд нь шийднэ гэвэл өрөөсгөл.

Монголбанк инфляцийг энэ оны эцэс гэхэд найман хувь, 2015-2016 онд долоон хувиас хэтрэхгүй түвшинд байлгах зорилт дэвшүүлсэн. Энэ сарын байдлаар инфляци улсын хэмжээнд 12.3 хувьтай байгааг Үндэсний статистикийн хорооноос зарласан билээ. Төвбанкны Ерөнхийлөгч инфляцийг найман хувь руу “гулсана” гэдэгт бат илтгэлтэй байгаа юм. Нөгөөтэйгүүр жил дараалан зөөлөн бодлого хэрэгжүүлж буй Төвбанк бодлогын хүүгээ өсгөх гэж яарахгүй байгаа.

Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэдэх Мөнгөний бодлогын зөвлөл дээрх асуудлаар хуралдаад бодлогын хүүг хэвээр үлдээсэн. Хэрэв бодлогын хүүг өсгөсөн тохиолдолд валтын ханш буурах ч ажлын байр хумигдах эрсдэлтэй аж. Мөн өнгөрсөн хугацаанд явуулсан эдийн засгийн тэлэх бодлогынхоо эсрэг ажиллагаа болох тул огцом нэмэхгүй болов уу гэсэн таамгийг зарим эдийн засагчид хэлж буй. Инфляцийг нэг оронтой тоонд царцаах нь Монголбанкны амлалт. Энэхүү амлалтаа биелүүлэхийн тулд хэрэглэгч бус үйлдвэрлэгч Монгол Улс болохыг мөнгөний бодлого онцолж буй. Үйлдвэржилтийг дэмжсэн мөнгөний бодлого улс төрийн эрсдэлээс болж саатахыг ч үгүйсгэхгүй. ■



ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛД

ЭРЭЛТ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС


Энэ удаагийн буландaa микро эдийн засгийн үндсэн ухагдахууны нэг болох бүтээгдэхүүний эрэлт, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар авч үзнэ.

Хэрэгцээ ба Эрэлтийн холбоо, Бүтээгдэхүүний эрэлт гэсэн ухагдахууныг авч үзэхийн тулд хэрэгцээний талаарх ойлголттой танилцах шаардлагатай болдог. Хүмүүсийн хангагдаагүй хүсэл, шаардлагыг хэрэгцээ гэдэг. Хэрэгцээгээр бүрэн хангах бодит боломж буюу мөнгө, санхүү, эдийн засгийн чадавх хүн бүрт байдаггүй. Бүтээгдэхүүнээс сонголт хийхдээ хүмүүс юун түрүүн түүнийг хэрэглэх хүсэлтэй, дараа нь худалдан авах мөнгөтэй байх шаардлагатай болдог. Хэрэглэгчийн худалдан авахыг хүссэн бөгөөд худалдан авч чадах боломжтой бүтээгдэхүүний тоо хэмжээг тухайн сонгосон бүтээгдэхүүний эрэлт гэнэ. Өөрөөр хэлбэл хэрэглэгчийн худалдан авах чадвартай хэрэгцээ юм. Гэхдээ хэрэгцээ нь бүхлээрээ эрэлт болохгүй, эрэлт нь хэрэгцээний төлбөрийн чадвараар баталгаажиг, бодит арилжаа хийгдэх бололцоотой хэсэг болно. Хэрэгцээ байгаад түүнийг худалдан авах чадвар байхгүй тохиолдолд эрэлт үүсэхгүй. Нэг үгээр хэлбэл хэрэгцээ нь эрэлт, мөрөөдөл хоёрын нэгдэл юм. Мөрөөдөл төлбөрийг нь хийх боломжгүй хэрэгцээний хэсэг болно. Эрэлт нь

худалдан авч хэрэглэх хүсэлтэй болон төлбөрийн чадвартай байх гэсэн хоёр шинжийг давхар багтаадаг ухагдахуун болой. Тухайлбал нэг хэрэглэгчид байртай болох хэрэгцээ байгаа боловч төлбөрийг нь хийх мөнгөгүй бол мөрөөдөл болох ба хэрвээ худалдан авах мөнгөө хуримтлуулж чадсан бол энэ хэрэгцээ эрэлт болно.

Эрэлтийн тоо хэмжээ ба Эрэлтийн муруй. Тухайн орчинд тогтоогдсон үнийн түвшинд “үнийн бус бусад хүчин зүйл тогтмол байхад” сонгосон бүтээгдэхүүнээс хүмүүсийн худалдан авахаар санал болгож байгаа тоо хэмжээг түүний эрэлтийн тоо хэмжээ гэнэ. Эрэлтэд нөлөөлдөг хамгийн чухал хүчин зүйл нь тухайн бүтээгдэхүүний үнэ юм. Бүтээгдэхүүний үнэ өсвөл эрэлтийн тоо хэмжээ буурч, харин үнэ буурахад эрэлтийн тоо өсдөг. Үүнийг эрэлтийн хууль гэнэ. Энэ хууль ихэнх бүтээгдэхүүн дээр биелдэг. Эрэлтийн хууль яагаад биелдэгийг орлуулалтын нөлөө, орлогын нөлөө гэсэн ойлголтуудаар дамжуулан тайлбарладаг. Бүтээгдэхүүний харьцангуй үнэ буюу тухайн бүтээгдэхүүний үнийг бусад бүтээгдэхүүний үнэтэй харьцуулсан харьцаа өсөхөд хүмүүс сонгосон бүтээгдэхүүнээ өөр бүтээгдэхүүнээр орлуулахыг эрмэлздэг. Энэхүү орлуулалтын нөлөөнөөс тухайн бүтээгдэхүүний эрэлтийн тоо хэмжээ

буурна. Мөн бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотой хэрэглэгчийн харьцангуй орлого (Орлогыг үнэд харьцуулсан харьцаа) буурч, хүмүүс өмнө нь худалдан авч байсан хэмжээгээрээ авч чадахгүйд хүрдэг. Энэ нь орлогын нөлөөнөөс буурч байгаа эрэлтийн тоо хэмжээ юм. Эрэлтийн тоо хэмжээ ба тухайн барааны үнэ хоёрын энэхүү урвуу хамаарлыг харуулсан графикийг эрэлтийн муруй гэж нэрлэдэг. Эрэлтийн муруй нь тодорхой хугацааны дотор хэрэглэгч ямар үнээр, сонгосон бүтээгдэхүүнээс ямар хэмжээтэйг авч чадах вэ гэдгийг харуулдаг.



Эрэлтийн муруй нь хэрэглэгчийн худалдан авалтын төлөвлөгөөнд нөлөөлөгч “үнийн бус бусад хүчин зүйл тогтмол байхад” бүтээгдэхүүний үнэ ба эрэлтийн тоо хэмжээний хоорондын хамаарлын дүрслэл юм. ►►

▶ Эрэлтэд нөлөөлөгч үнийн бус бусад хүчин зүйлсийн нөлөө. Эрэлтэд тухайн бүтээгдэхүүний өөрийн нь үнээс гадна

- Орлох бүтээгдэхүүний үнэ
- Хослох бүтээгдэхүүний үнэ
- Хэрэглэгчийн орлого
- Зар сурталчилгаа
- Ирээдүйд хүлээгдэж буй орлого
- Ирээдүйд хүлээгдэж буй үнэ
- Хэрэглэгчийн тоо

гэсэн хүчин зүйлс нөлөөлдөг ба эдгээрийг тухайн бүтээгдэхүүний үнийн бус бусад хүчин зүйлс гэдэг.

Орлох бүтээгдэхүүн нь сонгосон бүтээгдэхүүний оронд хэрэглэгдэх, хэрэглээний зориулалт нь яг ижил, эсвэл хэсэгчилсэн байдлаар ижил байх өөр нэг бүтээгдэхүүн юм. Тухайлбал АИ92 болон АИ95 бензин, шингэн ба хуурай сүү зэрэг нь орлох бүтээгдэхүүнүүдийн жишээ болно. Бидний авч үзэж буй бүтээгдэхүүний орлох бүтээгдэхүүний үнэ өсвөл, түүний харьцангуй үнэ нь буурч, улмаар эрэлт нь ихэсдэг.

Хослох бүтээгдэхүүн нь тухайн бүтээгдэхүүнтэй хамтдаа хэрэглэгддэг өөр нэг бүтээгдэхүүн юм. Тухайлбал, талхтай масло, жимсний чанамал, машинтай бензин хосолж хэрэглэгддэг. Тиймээс хослох бүтээгдэхүүний үнэ өсвөл авч үзсэн бүтээгдэхүүний эрэлт буурдаг. Учир нь эцсийн хэрэглээний зардал нь нийт дүнгээрээ өсдөг.

Хэрэглэгчийн орлого өсөхөд зарим бүтээгдэхүүний эрэлт ихэсдэг бол, заримынх нь буурдаг. Энэ чанараар нь бүтээгдэхүүнийг хэвийн ба дорд (чанар муутай) бүтээгдэхүүн гэж ангилдаг. Хэвийн бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн орлого өсөхийн хэрээр эрэлт нь өсдөг бол орлого өсөхөд эрэлт нь буурдаг бүтээгдэхүүнийг дорд бүтээгдэхүүн гэдэг. Хүмүүс

орлогоо өсөхөд бүтээгдэхүүн худалдан авахдаа хоёр янзаар ханддаг. Нэг нь харилцан орлох бүтээгдэхүүнүүд дундаас аль болох чанартайг нь сонгохыг эрмэлздэг бол нөгөөх нь хуучин авч байсан тоо хэмжээгээ өөрчлөх үйл хөдлөлийг хийдэг. Энэ хоёр хандлагаас орлого, орлуулалтын нөлөө гэсэн ойлголт гардаг. Орлуулалтын нөлөөгөөр хүмүүс орлого багатай байхдаа чанар муутай бүтээгдэхүүнийг хэрэглэж байгаад орлогоо өсөхөөр чанартай бүтээгдэхүүний худалдан авалтаа ихэсгэж, хуучин хэрэглэж байсан бүтээгдэхүүний эрэлтээ бууруулдаг. Угаасаа чанар сайтай бүтээгдэхүүн хэрэглэж байсан хэрэглэгч нь тухайн бүтээгдэхүүнийхээ худалдан авалтыг ихэсгэдэг. Энэ нь орлогын нөлөө болно. Зар сурталчилгаа нь тухайн бүтээгдэхүүний эрэлтийг ихэсгэх зорилготой байдаг.

Хэрэв бүтээгдэхүүний үнэ ирээдүйд өснө гэж хүмүүс хүлээвэл, үнэ багатай дээр нь ахиу авья гэсэн бодлоос өнөөгийн эрэлт өсдөг бол буурна гэж бодвол, хямдарсан үед нь авахаар хүлээж, өнөөгийн эрэлт буурна. Харин ирээдүйд орлого өснө гэж хүмүүс хүлээж байгаа бол өнөөгийн эрэлт өсдөг. Учир нь цаашид орлого өсөх тул тэр үедээ хадгаламж хийе, өнөөдөр байгаа мөнгөө хэрэглэе гэсэн бодлоор үйл хөдлөл хийдэг. Зарим хүмүүс зээл авч өнөөгийн хэрэглээний зардлаа ихэсгээд, ирээдүйд олох өссөн орлогоороо зээлээ төлөхөөр тооцдог.

Сонгож авсан бүтээгдэхүүний хувьд зөвхөн тухайлсан нэг хэрэглэгчийн эрэлтийг авч үзэж байгаа бол хувь хүний эрэлт гэх ба тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд буй хувь хүмүүсийн эрэлтүүдийн нийлбэрийг зах зээлийн эрэлт гэнэ. Өмнөх хүчин зүйлсүүд нь хувь хүний эрэлтэнд нөлөөлөгч хүчин зүйлс бол хэрэглэгчийн тоо нь зах зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлс болно. Хэрэглэгчийн тоо өсөхийн хэрээр бүх


бүтээгдэхүүний эрэлт ерөнхийдөө өсөх хандлагатай байдаг.

Эрэлтийн муруйн дагуух шилжилт. “Үнийн бус бусад хүчин зүйл тогтмол” байхад тухайн бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөхөд эрэлтийн тоо хэмжээ өөрчлөгдөж, эрэлтийн муруйн дагуу шилжилт хийнэ. Үүнийг дараах байдлаар графикаар дүрсэлдэг.



Эрэлтийн муруйн шилжилт.

Хэрэв тухайн бүтээгдэхүүний үнэ өөрчлөгдөөгүй байхад эрэлтэнд нөлөөлөгч “үнийн бус бусад хүчин зүйлийн” аль нэг нь өөрчлөгдсөн бол эрэлт өөрчлөгдөж, эрэлтийн муруй шилжилт хийнэ. Энэ нь эрэлтийн өөрчлөлтийг бий болдог. Хүмүүсийн худалдан авахаар төлөвлөж байсан бүтээгдэхүүний тоо хэмжээ үнийн түвшин бүрт харгалзан өөрчлөгдөнө. Иймээс шинэ эрэлтийн муруй үүсдэг. Эрэлт өсөхөд эрэлтийн муруй баруун тийш шилжинэ. Эрэлт буурахад эрэлтийн муруй зүүн тийш шилжинэ. Үүнийг дараах байдлаар дүрсэлнэ. ■



ХУРАЛ

ЕРЭН ЖИЛИЙН ХӨГЖИЛ

Б.АЛТАЙ

Монголын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний хурал энэ сарын 6-7-нд Улаанбаатар хотноо болсон билээ. СЭЗДС-ийн 90 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлыг доктор, профессор С.Будням “Эдийн засагчдийн их хурал” хэмээн онцолсон юм. Монголын ууган их, дээд сургуулиудын томоохон төлөөлөл нь СЭЗДС. Тиймээс “эдийн засагчдын их хурал”-д тооны ухааныхан өргөн хүрээнд идэвхтэй оролцож, өөрсдийн бүтээлээ “шалгууллаа”. Зөвхөн бүтээлээ шалгуулаад зогсохгүй шинэ аргачлал, өмнө нь нээж амжаагүй байсан нарийвчлал гээд судалгаа шинжилгээний салбарт үсрэнгүй дэвшил гарч байгааг харууллаа.

СЭЗДС-ийн Эдийн засгийн онолын тэнхмийн эрхлэгч, доктор, профессор Ц.Батсүх “Судалгааны загварчлал

шат ахиж байгааг хоёр өдрийн турш хэлэлцсэн судалгааны бүтээлүүд нотоллоо. Тухайн бодлогын асуудлыг урьдчилж харах судлаачдын чадвар эрс сайжиржээ. Хэлэлцсэн илтгэлүүд бодлогын том асуудлыг босгож ирлээ. Энэ бүхэн нэг цул болж байж эдийн засгийн хөгжлийн бодлогыг тодорхойлно” гэв.

Эрдэм шинжилгээний хуралд оролцсон их, дээд сургуулийн эрдэмтэн багш нар нийгэм, эдийн засгийн хүрээлэн байгуулахаар санал нэгдсэн юм. Тэд хамтарсан хүрээлэнтэй болсноор судалгааны хөгжилд дорвитой ахиц гарна гэцгээж байсан. Эрдэм шинжилгээний судалгааны нэгдсэн төвийг СЭЗДС-ийн дэргэд байгуулах санал багагүй дэмжлэг авсан. Тиймээс ирэх намар гэхэд судалгааны төв үүдээ нээх бололтой.

Дэлхийн санхүүгийн хямралыг үүсгэсэн нь санхүүчид гэдэг. Гэхдээ хямралыг эмчлэх хүмүүс нь тэд. Тиймээс эдийн засгийн судалгаанд

илүү ач холбогдол өгч, нэг удаа хэлэлцээд өнгөрөх бус судалгаатай бодлогыг чухалчилж байх асуудлыг энэ үеэр оролцогчид хөндөж байсан. “Улаанбаатар Эрдэм Оюу” дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч, эдийн засгийн ухааны доктор, профессор Н.Содномдорж “Феодализмын үеэс мөнгөн тэмдэгт “дүгэргий” маань Оросоор дамжаад буруу дуудлагаар дуудагдаад төгрөг болоод ирснийг Ц.Даваадорж докторын илтгэлээс мэдлээ. Мөн социализмын үед Сталин 200 сая малтай бол гэж хэлж байсан Монголын эдийн засаг бараг Оросыг бүхэлд нь тэтгэх түвшинд байсныг илтгэнэ. Монголын эдийн засгийн 100 жилийн тоймыг нэгтгэж зоригтой ярих хүн энэ эрдэмтнээс өөр байхгүй” гэлээ.

Эрдэм шинжилгээний хурлын нэгдсэн хуралдааны эхний илтгэлийг СЭЗДС-ийн захирал Ц.Даваадорж багш хэлэлцүүлсэн юм. Тэрбээр илтгэлдээ Монголын эдийн засгийн 100 жилийг үечлэн түүхэн гурван үе шаттай авч үзсэн бөгөөд Феодализмын хөгжил, Социализмын хөгжил, Зах зээлийн эдийн засаг гэж тодорхойлжээ. Харин доктор, профессор С.Будням “Манайх цус сорогчийн эдийн засагтай болжээ. Байгалийн нөөцийг хайр гамгүй иддэг, цөлмөж байгаагаар үүнийг тайлбарлана” хэмээн шинэ цагийн эдийн засгийг хатуухан шүүмжилсэн.

Зургаан салбар хуралдаанаас бүрдсэн эрдэм шинжилгээний хурлын хамтран зохион байгуулагчаар Монголын маркетингийн холбоо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо оролцсон юм. Манай сэтгүүлийн хувьд мэдээллийн ивээн тэтгэгчээр ажиллалаа. Бид сэтгүүлийн дараа дараагийн дугаартаа эрдэм шинжилгээний хурлын үеэр тавьсан сонирхолтой судалгаанаас уншигч танд “Бодлогын судалгаа” булангаараа хүргэх болно.

Бодлогын судалгаа:

Удирдлагын академийн багш, доктор, профессор Д.Нарандэлгэрийн “Монгол орны хөгжил, эдийн засгийн өсөлтийн харилцаа хамаарал” сэдэвт судалгааны товч дүгнэлтийг хүргэж ➤



байна. Тэрбээр судалгаанд хүний хөгжил, амьдралын чанар, амьдрах орчин нь тухайн орны хөгжлийн түвшинг тодорхойлно гэж үзжээ.

Манай орны хувьд эдийн засгийн өсөлтийг ДНБ-ий өсөлтөөр бус үндэсний орлогын өсөлт, хүн амын бодит орлогын өсөлт, хүмүүн капиталын чанарын өсөлт зэрэг үзүүлэлтээр хэмжих. Ингэснээр эдийн засгийн тогтвортой байдлынхаа замналыг зөв жолоодох асуудал нэн чухал байгааг тус судалгаанд онцолжээ.

Сүүлийн таван жилд өрхийн мөнгөн орлогын хэмжээ дорвитой өсөөгүй байгаа юм. Гэтэл энэ хугацаанд ДНБ-ий өсөлт өндөр хувьтай байсан нь судалгаагаар тогтоогджээ. Манай орны ДНБ-ий салбарын бүтцийг харахад уул уурхай олборлолтын салбар давамгайлж байна. Энэ салбарт ДНБ-ий 20-30 хувийг үйлдвэрлэж байгаа ч нийт ажиллагсдын дөнгөж дөрвөн ажиллаж байгаа юм.

Эдийн засгийн өсөлт нь өөрөө өртөгтэй. Энэ үнэ өртөг нь одоо үе болон хойч үеийнхэнд ямар үр дагавартай болохыг тооцож үзэх нь чухал байгааг тус судалгаанд дурьджээ. Эрдэмтдийн тодорхойлж байгаагаар эдийн засгийн таван төрлийн муу өсөлт байна. Үүнд:

- Дуу хоолойгүй өсөлт
- Эдийн засгийн тэгш бус өсөлт буюу харгис өсөлт
- Соёл уламжлалаа хүнийсгэх өсөлт
- Ирээдүйгүй өсөлт
- Ажилгүй өсөлт

Сүүлийн гуч гаруй жилийн хугацаанд ихэнх улс оронд хүмүүн капиталд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж ирсэн байна. Зарим оронд хүмүүн капиталд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь үйлдвэрлэлд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс хэд дахин илүү гарах болжээ. Өндөр хөгжилтэй орнуудад боловсролын түвшин, амьдралын турш олох орлого хоёрын хооронд тогтвортой хамаарал хэдийнэ төрхөө

олсон. Манай орны хувьд хүний боловсрол, чадвар, туршлагын түвшингээс хамааран олох орлогын хэмжээ илүү байх нь тэр бүр илэрч харагдахгүй байгаа аж.

Мөн хүн амын ихэнх нь хүнсний болон бусад зүйлийн наад захын хэрэгцээгээ бүрэн хангаж чадахгүй байгаа. Энэ нь сөрөг үзэгдэл бий болгож байна. тухайн хүн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээгээ бүрэн хангаж байж л эрүүл, урт насалж, эрчимтэй ажиллаж, баялгийг бүтээж чадах юм. Хүн амын цөөн хувийг эзэлж байгаа чинээлэг хэсгийн 20 хувийн хэрэглээний дундаж хэмжээ нь ядуу хэсгийн 20 хувийнхаас 5.3 дахин өндөр байна.

Нэг өрхийн орлого, зарлагын өнөөгийн байдалд хийсэн судалгаанаас үзэхэд эдийн засгийн өсөлтөөс хамаарч өрхийн орлого зарлага тоон болон чанарын үзүүлэлтээр өссөн байдал ажиглагдахгүй байгааг судалгаанд өгүүлжээ. Ядуурал нь зөвхөн орлогын хомсдолоор тодорхойлогдохгүй. Энэ нь хүмүүс амьдралдаа сонголт хийх бололцоо боломжоор гачигдан хомсдож байгааг илэрхийлэх үзүүлэлт юм. Манай орны хувьд дотоодын нийт бүтээгдэхүүний хот, аймгийн хуваарилалт харилцан адилгүй эрс зөрөөтэй байгаа нь ядуурал, орлогын хомсдолд нөлөөлж байна гэж “Монгол орны хөгжил, эдийн засгийн өсөлтийн харилцаа хамаарал” судалгаанд үзжээ.

Дүгнэлт:

1. Монгол орны эдийн засгийн өсөлтийн байдалд хийсэн судалгаанаас үзэхэд өсөлт нь өөрийн дотоод эрчим хүч болох хөдөлмөр, капиталын бүтээмж хүмүүн капитал зэрэг хүчин зүйлийн нөлөөллөөс хамаарахгүй байгаа байдал ажиглагдаж байна.
2. Эдийн засгийн өсөлтийг улс орны хөгжлийг хангах гол үндэс суурь болгох үүднээс юуны түрүүнд салбарын бүтцийг оновчтой болгох асуудал тулгамдаж байна. Энэ чиглэлээр хөдөө аж ахуйг аж үйлдвэржүүлэх, дэвшилтэт шинэ технологид суурилсан орчин үеийн үйлдвэрүүдийг алс

хэтийн бодлоготойгоор байгуулах нь чухал.

3. Салбарын бүтцийг оновчлох бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын бүтцийн ашигт чанарыг нь дээшлүүлэх чиглэлээр өөрчлөн сайжруулах боломжтой.
4. Хөрөнгө оруулалтын бодлого, бүтцийг оновчлохын хэрээр ажилгүйдэл буурч, хүн амын амьжиргааны төвшин дээшилж, хөдөлмөр, капиталын бүтээмж өсөх боломжтой.
5. Монгол орны хөгжлийн гол тулгуур болох хүмүүн капиталын хөгжилд эртнээс анхаарч, боловсрол, эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
6. Боловсруулах аж үйлдвэрийн салбар ДНБ-ий дөнгөж найман хувийг эзэлж байгааг өөрчилж үйлдвэржилтийг нэн хурдацтай явуулах шаардлагатай байна. Гэхдээ чухам ямар үйлдвэрийг, ямар кластерийг, хаана хэрхэн байгуулах вэ гэдэг асуудлыг шийдэхдээ нэн хурдацтай түрэн орж ирж байгаа цөлжилт /20 жил тутам 150 км-ээр/ эргэн сэргээгдэхгүйгээр элэгдэж бохирдсон байгаль орчны нөхцөл, хүмүүсийн боловсролын төвшин, усны нөөцийн эрс бууралт зэргийг нарийн нягт харгалзан үзэх.
7. Тогтвортой хөгжлийн нэг гол эрхэм зорилго болсон хойч үеийнхэндээ амьдрах таатай орчныг үлдээх үүднээс эрүүл, ажилтай, ухаалаг, бүтээлч монгол хүнийг хөгжүүлэхийн тулд өндөр боловсролтой, бүтээлч залуучуудыг урамшуулах. Тэдний мэдлэг чадварыг аль болох бүрэн ашиглах, өндөр цалин, амьдралын нөхцөлөөр хангах.
8. Хүний хөгжих боломж, амьдрах таатай орчныг нь бүрдүүлсэн олон тулгуурт баттай эдийн засгийн суурийг бий болгох. Энэ нь монгол хүн бүрийн хүсэл мөрөөдөл мөн бөгөөд зөв бодлогын үндсэн дээр биелэх бүрэн боломжтой. ■

ТЕХНОЛОГИ

Аль улсуудын эдийн засаг хамгийн сайн мэдээлэл, харилцааны технологийг / МХТ/өргөн ашиглаж, дижитал хуваагдалуудын гүүр нь болж, том мэдээллийн сангийн ач тусыг үнэмлэхүй хүргэж чадаж байна вэ?

Энэ оны "Дэлхийн мэдээлэл технологийн тайлан: Мэдээллийн сангийн эрсдэл ба боломжууд" гэх үзүүлэлт өнгөрсөн дөрөвдүгээр сард гарлаа. Үүнд 145 орныг дижитал дэд бүтцийн чанар, инновацийг дэмжих байдал, МХТ-ийг хэрхэн чадварлаг ашиглаж эдийн засгийн өсөлтийг залуурдаж, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулж байгаагаар нь жагсаажээ.



МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙГ ГАРАМГАЙ ЗЭЭМШСЭН 10 ОРОН

Тэгвэл энэхүү жагсаалтын эхний 10 орныг танилцуулья.

- 1. Финлянд** улс хоёр дахь жилдээ энэхүү жагсаалтыг тэргүүлж байна. Дэлхийн мэдээлэл технологийн тайлан тус улсыг хамгийн шилдэг дижитал дэд бүтэцтэй гэж үнэлжээ. Хүн амынх нь 90 хувь нь инновацийн өндөр түвшинд интернэт хэрэглэдэг байна. Фяланд нь 1990 оноос санхүүгийн хямралын хариу арга хэмжээнийхээ нэг хэсэг болгож энэ салбарт эрчимтэй хөрөнгө оруулалт хийж эхэлсэн юм.
- 2. Сингапур** улс энэ жил хоёрдугаар байр эзэлж байгаа нь Засгийн газар нь тодорхой дижитал стратегиар дэмжиж мэдээлэл технологийн салбарын дэд бүтцээ тасралтгүй өөд нь татаж байгаатай холбоотой аж. Тус улс хамгийн шилдэг цахим үйлчилгээ болон өндөр чанарын боловсролын системийг санал болгодог орон болж чадсан билээ. Түүнчлэн тус хот-улсын хөгжлийг мэдээлэл технологийн төвлөрөл, мэдлэгт суурилсан эрчимт эдийн засаг тодорхойлж байна. ➤

- 3.** **Швед** улс энэ удаад гуравдугаарт орж байгаа нь хэдийгээр өндөр татвар ногдуулдаг ч дэлхийн хэмжээний атлаа боломжийн үнэтэй дижитал дэд бүтэц, бизнест ээлтэй тогтвортой орчныг бүрдүүлж чадсантай холбоотой. Эдгээр чадавхи нь тус улсын иргэд, бизнес, төрийн байгууллагууд мэдээлэл харилцааны технологийг гарамгай эзэмшиж өдөр тутам хэрэглэдэг болгожээ. Түүнчлэн инновацийн үзүүлэлтээр шилдгүүдийн нэгт зүй ёсоор багтдаг зэрэг нь мэдлэгт суурилсан нийгэмтэй улс гэж нэрлэгдэхэд хүргэдэг юм.
- 4.** **Нидерланд** улс 2013 онд үзүүлж байсан амжилтаа энэ жил алдалгүй тогтоож үлджээ. Үйлчилгээнд суурилсан эдийн засагтай тус орон хурдан хугацаанд мэдээлэл технологийн ач холбогдлоо таньж чадсан юм. Тиймдээ ч энэ чадавхи инноваци өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чадварлагаар чиглүүлж байна. Мэдээллийн технологи Нидерландын нийгмийн бүх хэсэгт нэвтэрсэн. Тус улсын иргэн, өрх бүр компьютертэйгээс гадна цахим ертөнцөд холбогдсон байдгийн зэрэгцээ төрийн үйлчилгээний дийлэнх нь цахим хэлбэрт шилжсэн байдаг.
- 5.** **Норвеги** нь сайн хөгжсөн боломжийн үнэтэй мэдээлэл харилцааны технологиос бүрдсэн дэд бүтэцтэй учир жагсаалтын тавдугаарт эгнэж байна. Дижитал хэрэглээ нь Норвеги улсын хувьд бүх нийтийг хамарсан байдаг байна. Тухайлбал, хүн амынх нь 95 хувь интернэт хэрэглэгч байдаг бол 90 хувь нь суурин компьютертэй болон гэртээ интернэт холболттой байдаг байна. Мөн Норвегид тус салбарын нийгэм эдийн засагт үзүүлэх ач холбогдлыг бүрнээ ухамсарласан Засгийн газар, бизнест ээлтэй тогтвортой, инновацилаг орчин ихийг өгч байгаа билээ.
- 6.** **Швейцарь** нь мэдээлэл харилцааны сайн дэд бүтэц, хүчирхэг боловсролын системээр дамжуулан ур чадвартай боловсон хүчнийг бий болгож мэдлэгт суурилсан, технологиор баян эдийн засгийг бүрдүүлж буй улс юм. Тогтвортой улс төр, эрх зүйн орчин, бизнес эрхлэгч, инновацийн хувьд таатай нөхцөл байдал нь дээрх хөрөнгийн үнэлэмжийг хадгалж байна. Үүний дүнд, тус улсын бизнесүүдэд дижитал дэд бүтэц өргөн хэрэглэгдэж байна.
- 7.** **Америк** улсын хувьд энэ жил хоёр байр урагшилж, жагсаалтын долдугаарт ороод байна. Үүнд тус улсын олон мужид үзүүлэлт сайжирсан нь нөлөөлжээ. Түүнчлэн олон жил хадгалагдаж буй бизнес болон инновацийн хүчирхэг суурь орчин, мэдээлэл харилцаа технологийн дэд бүтэц тэр дундаа олон улсын цахим ертөнцийн сүлжээнд холбогдсон өргөн цар хүрээ нь голлох байр суурь эзэлж байна. Төр, хувийн хувшил болон иргэд ялгаагүй нийт орон даяар жил ирэх тусам дижитал технологийн нэвчилт явагдаж байна.
- 8.** **Хонконг** нь ТОП 10 дотроо энэ жил хамгийн тэмдэглэм амжилтыг үзүүлж зургаан байр урагшилж чаджээ. Үүнд аж ахуй нэгж болон инноваци хөгжих орчин сайжирч, мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулах сайн сургалтууд, бизнес болон Засгийн газрын дижитал хэрэглээ өссөн нь нөлөөлжээ. Хонконг улс нь сайн хөгжсөн дэд бүтцээс ихээхэн өгөөжийг хүртдэг бөгөөд энэ нь ч эдийн засаг, нийгэмд эерэг нөлөөг үзүүлж байна.
- 9.** **Их Британи** улс өмнөх жилтэй харьцуулахад хоёр байр ухарчээ. Нидерландтай адил тус улс нь инноваци болон өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд мэдээлэл харилцаа технологийн ач холбогдлыг таних эхний шатандаа явж байгаа. Үүний дүнд улс даяараа өндөр түвшнд дижиталчлагдаж, цахим худалдааны орчин үлэмж хэмжээнд томорч байна. Үүнийг тус улс бизнест ээлтэй орчинтой хослуулж байгаа нь эдийн засаг, нийгмийн үр ашгийг нэмэгдүүлж байгаа юм.
- 10.** **Өмнөд Солонгос** энэ жил нэг байр урагшилж ТОП 10 орны жагсаалтад шинээр орж ирсэн юм. Эдийн засгийн амжилт нь мэдээлэл харилцаа технологийн салбар дээр бат суурилсан байдаг улс бол Солонгос. Тус улсын Засгийн газрын цахим үйлчилгээ дэлхийд нэгдүгээрт ордог. Өмнөд Солонгос улс эдийн засгийн хөгжлийн стратегийнхаа нэг хэсгийг технологийн чадавхийг сайжруулж хөгжүүлэх гэж үзэж, энэ хэмжээнд бодлого чиглэлийг нь тодорхойлж байдаг. Тиймээс ч үүний дүнд инновацийн хувьд нэр хүндээ өсгөсөөр байна.

Эх сурвалж World Economic Forum ■

БИЗНЕСМЭНИЙ ДУУ ХООЛОЙ

Б.ТӨМӨРЧУЛУУН: МАНАЙ ТӨР ӨОЛКНЫ МОД ШИГ БАЙНА

Д.БЭХЭЭ

Үйлдвэрлэл дагнасан “Сэргэн Мандалт” группийн Ерөнхийлөгч Б.Төмөрчулуунтай ярилцлаа.

-Төр улсын талаарх таны бодлыг эхлээд сонсоё. Учир нь Та Монголоо бас төрөө цэвэр цэмцгэрийн дээд яаман ухааны уурхай байх ёстой гэж хэлсэн шүү дээ.

-Төр бүр ялангуяа Монголын төр ард түмнийхээ эргэж хувирдаггүй сайн анд нь байх ёстой. Хувиршгүй анд гэдэг бол нэг зантай, цөөхөн үгтэй, амалснаа биелүүлдэг, уул ус шиг түшигтэй, эцэг шиг нь зангарагтай, ээж шиг нь энэрэлтэй байх ёстой. Гэтэл бидний анд маань хувираад байна. Төр хувирахаар дагаад хүн ард нь хувирдаг боллоо. Дээрээ гүйдлээ олохгүй байхад доороо яаж олдог юм бэ гэсэн ардын маань үнэн үг бий. Төрийн эрх барих дээд шатны буюу нийгмийн харилцааг зохицуулах дээд шатны алтан жолоо цулбуурыг барьдаг хүмүүс нь эргэж хувираад байгааг би хэлж байна. Ард олон манай залуучууд соёолон морьд л гэсэн үг. Уяа сойлгыг нь тааруул.

УИХ-ын гишүүд гурван зүйлийг сайн анхаараасай. Нэгдүгээрт, Санамсар гэж юу юм бэ? Үүнийг ойлгож зүрх сэтгэлээ сайн дадуулах хэрэгтэй. Би хэнээс төрсөн хэн билээ, хэн байгаад хэн болсон гэдгээ сайтар тунгаан бодох. Хоёрдугаарт, анхааран авлага гэж юм бий. Тэгэхээр эх орноосоо, аав ээжээсээ, ард түмнээсээ, сонгогчдоосоо авахаа авчихсан. Харин одоо өглөгийн эх булгийг ундрлуулах, өгч чадах бүхнээ өгөх хэрэгтэй, өгөх юм байхгүй бол ядахдаа сайхан



Төр анд минь хувираад байна

ааштай, хүнд сурталгүй бай.

Гуравдугаарт, Үлдэх амьдрал гэж юу болох тухай бодох ёстой. Монгол орон мөнх үлдэнэ. УИХ-ын гишүүн мөнхөд байхгүй шүү дээ. Энэ бүхнийг сайн ойлгож манай УИХ-ын гишүүд бүгд нямбанд суу. Яагаад валютын ханш өсөөд байна, энгийн ардууд, найз нөхөд минь утсаар ярихад яагаад би утсаа авахгүй байна, яагаад би их мөнгө олоод байна, яагаад би албан тушаал хашмаар санагдаад байна, би ямар хоол идэж байна, би ямар өвөө, ямар өрхийн тэргүүн, ямар найз байна гэдгээ эргээд сайн бодож тунгаах хэрэгтэй. Нямбанд сууж Яаман ухаантай болохын тухайд амьдрал мэддэг хүнээс асуугаарай даа эрхэм гишүүд ээ.

Орчин үеийн шинжлэх ухаан, эдийн засаг, философын ухааны хэллэгээр ярьвал эргэж хараад зогтүсхийгээд дахин төлөвлө. Өнгөрснөө нэг эргээд хар л даа. Тэгээд дахин шинээр төлөвлөөсэй. Бизнесийн тогоонд 20

гаруй жил борц болтлоо чанагдсан, сүүлийн дөрөв гаруй жил нийслэлийн иргэдийг төлөөлж байгаа хүний хувьд ийм бодол төрөх юм. Өөрт тустайгаас илүү түмэнд тустай ажил хийх хэрэгтэй. Бүр ядахдаа хаягдал цаасан дээр нэрийн хуудсаа хэвлэ. Талцахаа болиосой. Нам бус Монгол чухал байна.

-Та монгол төрийг ёолкны модтой зүйрлэн ярьсан. Их сонин зүйрлэл шүү.

-Бид шинэ жилээр ёолк засах дуртай биз дээ. Үе үеийн төр ийм л гялтганасан байна л даа. Гаднаа гяланцаг дотроо паланцаг байгааг үе үеийн төрийн түшээд мэдсээр байвч засахгүй юм. 23 жил чамлахаар бага хугацаа биш ээ. Төр нуруун дээрх их ачаанаасаа салах шаардлагатай. Яргуй, Сарнай цэцэг шиг болох хэрэгтэй. Ард түмнийхээ төлөө үрээ өгөхийн тулд дэлгэрмээр байна. Ийм ийм зүйл рүү оролцохгүй гэдгээ зарлачих. Ялангуяа төр татвар ►

▶ төлөгчдийн мөнгөөр худалдан авах үйл ажиллагаа хийхгүй байх нь зөв. Яагаад гэвэл ичээд байх юм гэж хариул. Татвар төлөгчдийн мөнгөөр А4-ийн цаас л авъя, бусдыг бизнесмэнүүд мэдэг гэж хатуу бод. Ингэж бодож чадвал монгол төрийн жинхэнэ бодлого, уужуу ухаан болно. Монгол орныхоо алсын хараа, хөгжлийн бодлогыг яг л бяслаг шиг шахаад өгчих. Зүсэхийг нь аж ахуйн нэгжүүд, өөр бусад нь зүснэ биз. Ийм хөгжлийн бяслаг үйлдвэрлэдэг, тархи толгой нь цэцэн мэргэн төртэй, оюун ухааны уул уурхайн түшиц болсон улс баймаар байна. Монгол орон илт сэргэнэ. Харин одоо энэ буй байдлаар бол ерөөсөө болохгүй гэдгийг л би зөвлөж хэлэх гэсэн юм. Бүх түвшинд шүү. Улаанбаатарчуудын их унтаж, уурлаж ундууцахад хэзээ ч бэлэн байгаагаас эхлээд солонгос кино үзээд унтах хүртэл.

-Төр хувирч болохгүй гэж байна. Өнгөрсөн хугацаанд төр хувирахгүй байсан тохиолдол байгаа юу?

-1990 онд худал хэлсэн баймааргүй. Хүнлэг ардчилсан иргэний нийгэм байгуулна гэхчхэн. Тэрийгээ мартаад одоо нам төвтэй Монгол улс болсон. Тэрийг хувиргаж, эргүүтүүлээд буй зүйл бол нам. Намын нэрээр хэсэг нөхөд лобби, танил тал, хуйвалдаан хийж байна. Ард түмэн хувираагүй. Тэд монгол төрийн үнэнч хэвээр байгаа. Төрийн гаргасан алдаа, мөнгөний ханшны сулрал, агаарын бохирдолт, ажилгүйдэл, ядуурал, архидалт, авилгал бол төрийн муугынх. Энэ бүгдийг тэсвэрлэн суугаа уужуу ард түмэнтэй гэдгээ л сана. Ийм ард түмнийхээ ачийг нь үтэр түргэн хариулах хэрэгтэй.

-Төр юуг амлах ёстой вэ?

-Би энд зөвхөн эдийн засаг материаллаг талаас нь харж хэлье л дээ Миний бодлоор засаг хоёр зүйл амлаад, нэг зүйлийг нэхсэн шиг нэхэх хэрэгтэй. Нэгдүгээрт, зах зээлийн эдийн засгийн хэрэглээ талаасаа байнга эргэлддэг зүйл бол мөнгө. Ер нь мөнгө тооцоон дээр амлалт өгөх хэрэгтэй. Тухайлбал, төгрөгийн, долларын ханш гучин жил тогтвортой 500 төгрөг байна гээд амлаж, энэхүү амлалтынхаа төлөө ажиллаж, тэмцэж, амлалтаа биелүүлж

данагар байх хэрэгтэй. Хоёрдугаарт, та ийм хэмжээний татвар төлнө гэдгийг зарлах. Ялгавартай биш. Мөнгө эргэлдүүлж байгаа л бол тэр нэмүү өртгийн албан татвар төлнө. Түц ч төлнө. Чи их олдог 30 хувь, чи чааваас түц юм төлөөд хэрэггүй гэсэн яриа байх ёсгүй. Ард түмэн нэгэнт тогтоосон дүрэм журмыг ягштал биелүүлэх ёстой. Төр амлалтаа өгнө, иргэд татвараа төлнө. Амлалт, татвар хоёрын хоорондох зайнд улс хөгжиж, бизнес цэцэглэж сайхан амьдарна.

-Өнөөдөр бид бүх л бурууг, болохгүй байгааг төртэй холбодог. Төр муу менежер гээд л байнга ярих. Энэ зөв үү?

-Төрөөс их итгэл хүлээсэндээ л тэгж хэлээд байгаа юм. Засаг байгаа, засаглаж байгаа бол бидэнтэй адилхан л сайхан ааштай байгаач, татварыг тодорхой болгоод өгөөч, саад битгий болоочээ гэж л байгаа. Төр хэрэгтэй гэвэл хэрэгтэй. Төр юунд хэрэгтэй вэ. Ард түмэн алагтай цоогтой амьдрал эрээнтэй бараантай шүү дээ. Тиймээс асрах энэрэх ёстой. Аав шиг нөмөр нөөлөгтэй, ээж шиг энэрэлтэй байхыг хүсээд байна. Өөр зүйл хүсээгүй. Ер нь монголчууд дэндүү ухаалаг ард түмэн болохоороо төрөөс хүсч буй зүйл нь даруухан.

Ард түмний мэдэлд газар доорх баялаг л байх ёстой. Тэрнийг төр мэдсэн шиг мэдэх. Сүүлийн үед баялгаа ерөөсөө хувийн хэвшилд өгөөд байя гэсэн хандлага ажиглагдаж байна. Хувийн хэвшлийнхэн сурсан чадал чансаагаараа баялаг бүтээж эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулна. Түүнээс газар доорх баялгийг ухаж гаргаж ирснээр баялаг бүтээгч болчихдог юм биш. Баялаг ухагч болж байгаа юм. Тодорхой зорилго дэс дараатай төлөвлөгөөтэйгээр хийх нь төрийн ажил. Яг Франкфуртын олон улсын нисэх онгоцны буудалд диспетчерийн удирдлагаар онгоц бууж нисгэдэг шиг. Улс орны хөгжлийг хэмжихэд ядах юм байхгүй. Таксины жолооч, оюутан, бараан захын худалдагчтай ярилцаад л мэднэ. Тэд би аз жаргалтай сайхан амьдарч байна гэвэл төрийн сайн бодлогын хэмжүүр, эсрэг зүйл яривал тэр нь өнөөгийн төрд өгсөн дүгнэлт, ташуур. Улс орны хөгжлийг Ерөнхийлөгчөөс,

УИХ-ын даргаас асуух шаардлагагүй. Энгийн иргэдийн аманд монгол төрийн үнэлгээ хүлхэгдэж байдаг. Ийм учраас НИТХ-ын төлөөлөгчийн хувьд надад нэг даруухан мөртлөө Монголын төрийг иргэнлэг байхад ачтай санал байдаг. Иргэдийн хурлын төлөөлөгчдийг намаас нэр дэвшүүлэхээ больё. Өөрөөр хэлбэл 35 мянган хүнээс нэг нь л сонгогд. Намаас бол Улсын их хурал нь сонгогддог юм байгаа биз гэж бодох юм.

-Та 1990-ээд оноос бизнесийн зовлон жаргалыг биеэрээ туулж ирсэн бизнесмэнүүдийн нэг. Өнгөрсөн бизнесийн түүхээ эргээд харахад танд юу бодогдох юм?

-Залуусаа л хайрлах хэрэгтэй байна. Хэд нь хатуу системийн золиос болсон, хэд нь хэнэггүйхэн алхаж байна, хэд нь ухаажиж байна. Зах зээл өнөөдөр нэг төгрөгийн юмыг гурван төгрөгөөр зарах тухай яриа биш. Их мэдлэг шаардсан ажил. Гэтэл өнөөдөр мөнгө гэхээр л уул уурхай яриад байна. Уул уурхайгаас илүүтэй хамгийн чухал зүйл мэдлэгт суурилсан эдийн засаг. Үүнийг л эрчимтэй хөгжүүлбэл улс орон хурдацтай хөгжинэ. Монголчууд дэлхийн шинжлэх ухааны ололт амжилтаас булаалцалдан байж хүртэн нутагшуулмаар юм. Уул уурхайг төр зөв мэддэг байх юм бол тэр хэмжээгээр улсын хичин чадал нэмэгддэг байх нь. Нэгэнтээ улсын нэмэгдэх хүчин чадлыг өөртөө авч байгаа бизнесмэнүүдийг хүндлээд даалгавар өгөх ёстой. Уул уурхайн бизнес эрхэлж буй хүмүүс ийм ийм даалгаврыг гүйцэтгэх талаар тодорхой зааж өгөх хэрэгтэй. Харин тийм гэрийн даалгавартай нь үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүл. Уул уурхай ухсан хүмүүсээс Хөдөлмөрийн баатар төрөхгүй, уурхайчнаас харин төрж болно. Мэдлэгт суурилсан эдийн засаг шүтвэл эрдэмтэд олноор төрөх ёстой. Генийн суутнууд, оюун санааг дээдэлсэн хүмүүс олон болно гэсэн үг. Гэхдээ манай улсын өнөөгийн нөхцөлд буюу холилдсон байдалд баялгийн балансаа төр мэргэн гаргаж тайлангаа тавьмаар байна. Уул уурхайд амжилт олж буй нэгнээ дэмжих л ёстой. Төрөөс өгсөн үүрэг даалгаврыг хийж чадахгүй бол дараачийн хүндээ өгдөг ▶

► байх. Улс даалгасан шиг даалгадаг нөгөө тал биелүүлсэн шиг л биелүүлэх нөхцөл бүрдүүлэх нь чухал байна.

-Таны өрөөний цонхоор амьдрал ямар харагдаж байна вэ?

-Албан тасалгааны цонхоор амьдрал яг нүцгэн үнэнээрээ харагддаггүй. Энэ нүцгэн үнэнийг ойлгож буй хүн л очсон албан тушаалдаа заавал сайн ажиллана. Манай эдийн засаг өнөөдөр жишээлбэл, чардайсан резин шиг байна. Арай л тасраагүй. Энэ резиныг тосолж чадвал суларна. Гэхдээ хүчээр сулруулж болохгүй. Хайр энэрэлээр, зөв тэмцлээр сулруулах хэрэгтэй. Бүр тасалж болохгүй. Наад зах нь ханшийг тогтоох шаардлагатай. Амласан бол амласан ш дээ. Энэ жилийн валютын ханш 1341 байна гээд амалсан бол хэлсэндээ хүрэхээс өөр ямар ч арга байхгүй. Ханш 1800-д хүрвэл зөрүү мөнгийг нь өгөх ёстой. Бидний муулаад байгаа Оюутолгой валютын ханшийн зөрүүг зарим компанид уучлаарай гээд өгсөн байна лээ. Монгол Улс валютын ханшны зөрүүг өгөх ёстой. Гэхдээ бид шаардаагүй. Ханшийг тогтворжуулах асуудалд засаг сайтар анхаарах цаг ирсэн. Дугаарлаж буй асуудлуудаа эрх ашгаар нь байр эзлүүлж эхний таван байрын асуудлаа амь тавьж шийд. Валютын ханшаа зогсоож, ер нь асуудлуудаа нэг цэгцэлж авах цаг болжээ.

-Монгол бизнесмэнүүдийг дүгнээд хэлбэл?

-Монголын арилжааны банкууд бол мөнгө хүүлэгчид. Ийм өндөр хүүтэй бизнесийн циклд сөгдөлгүй тэмцсээр яваа хүмүүс бол монгол бизнесмэнүүд. Маш их самбаатай, хүчтэй, хурдтай, өвөрмөц улсууд. Маш үнэнч, тэдэнд итгэж болно.

-Ер нь монгол хүн гэж хэн юм бэ?

-Би "Тусгаар тогтнол" номондоо бичсэн. Генийн донж гэдэг содон бүтээгдэхүүн байдаг. Генийн донжоор хүнийг ямар ухаантай, ямар гаралтай мэддэг. Генийн давамгайлсан шинжээрээ дэлхийд гайхуулахаар, дэлхийн гал голомтыг тойроод суух хүмүүс Монголд байгаа юм шиг санагддаг. Монгол хүний генийн шинж маш сайхан, өгөгдөл сайтай, цэвэр. Монгол хүн давтагдашгүй дээ,

гайхалтай. Тийм ч учраас нандин хүмүүс.

-Сүүлийн үед эдийн засаг бус монгол хүмүүсийн сэтгэхүй нь хямарчихаад байна. Төрөө шүүмжилж, муулж, болох, болохгүй зүйл төрийн л буруу болдог болсон гээд.

-Хүн бүр тийм бодолтой биш л дээ. 20 гаруй жил нам төвтэй явлаа, манай улс. Дархлаа суусан байж болно. Монголын төр дээр хэлсэнчлэн эцэг эх шиг энэрэх ёстой. Хүүхдүүддээ туслах үүрэгтэй. Монгол Улсын эдийн засгийн тусгаар тогтнол, ёс зүй, бодлогоо бяслаг шиг болгохын

“ Залуусаа л хайрлах хэрэгтэй байна. Хэд нь хатуу системийн золиос болсон, хэд нь хэнэггүйхэн алхаж байна, хэд нь ухаажиж байна. Зах зээл өнөөдөр нэг төгрөгийн юмыг гурван төгрөгөөр зарах тухай яриа биш. Их мэдлэг шаардсан ажил. ”

тулд иргэдээ дархлаажуулах асуудал чухал. Солонгос кино үзсэнээр сэтгэхүй нь тэр бүр өөрчлөгдөхгүй байх.

Харин манай залуу үе гадаадад сурвал л болох нь тэр гэж үздэг болсон байна. Энэ бол тийм ч зөв шийдвэр биш гэж би боддог. Тийм учраас би МАХА гэж хөдөлгөөн үүсгээд яриад яваад байгаа юм.

МАХА гэдэг нь-Монголоороо л, Амьтайгаа л, Хүчирхэг л, Аугаа л байж Монголыг Аугаа Хүч Аварна (МАХА).

Тэрхүү аугаа хүч нь мэдлэг, уламжлал, зан заншил.

Наад зах нь монгол хүүхдийг 13-ны жил орох хүртэл нь монгол ахуйдаа л сургах хэрэгтэй. Ямар ч гадны

хэл заахгүй. Монгол наадгайгаар наадуулж, нагац, авга нарын талаар тодорхой ойлголт өгөх нь чухал. Монгол хүн, монгол ген, монгол ахуйг мэдэж, монгол сэтгэхүйтэй, монгол дархлаа суусных нь дараа өөрөө гадаад хэл сурахаа сонго.

Цаашлаад Монголдоо их, дээд сургуулийн диплом аваад ямар нэг газар ажиллана. Үүний дараа харин гадаадад мэргэжил дээшлүүлж, ажиллаж буй байгууллага, мэргэжлийнхээ хүрээнд гадаадад магистр хамгаалаад ирсэн бол хэрэгтэй. Энэ нь тухайн байгууллагын үнэт зүйл, Монголын баялаг болно. Түүнээс гадаадад магистр, бакалавр хамгаалсан хүмүүс одоо сонин биш болсон.

-Таны бизнесийн зарчим юу вэ?

-Бидний зөв зарчим бол өөрийнхөө чадлаар нэг ажлыг л хийх. Өөрөөр хэлбэл, манай группийн зарчим бол нэг чадлаар олон ажил хийх бус, нэг чадлаар нэг ажлыг чинээнд нь тултал хийх. Нэг чиглэсэн зүйлдээ амиа тавьтал ажиллах ёстой. Миний хувьд энэ нь үндэсний үйлдвэрлэл. Сая төгрөгнөөс санаа төрөхгүй, санаанаас сая сая төгрөг төрнө гэсэн өөр нэг зарчимтай яваад 20 жил болж байна. Заримдаа баярлах зүйл байна, нөгөө талдаа хэцүү зүйл ч тохионо. Үйлдвэрлэлээр дагнаж, амтыг нь мэдэрч, үйлдвэрлэл эрхлэхийн үр дүнг үзэж яваадаа бахархдаг. Манай групп бүх төрлийн хоолой, шуудайн үйлдвэрлэл эрхэлдэг. Бүх төрлийн хаягдлаас сүрэл гаргаж авахдаа мэргэшсэн туршлагатай компани. Хамгийн гол нь тусгаар тогтносон Монгол улсын иргэн болж төрсөндөө л баярлаж, бахархаж, жигүүрлэж явна даа.

-Таны хообий?

-Шүлэг бичих. Миний үгийг нь зохиосон арваад дуу бий. Саяхан би твиттэрт нэг шүлгээр жиргэсэн.

-Ямар шүлэг вэ? Сонирхъё.

*Хөхрөн цэлийж л байвал Монгол нутаг
Тэмээн жин хөвөрч л байвал Миний өвөө
Сүүн цацал цайрч л байвал Миний эмээ
Хүүхэд гадаа эрхээрээ тоглож
Хөгшид нарлаж байвал Монгол нутаг
гэсэн дөрвөн мөрт. ■*


CEO

2013 ОНЫ ДЭЛХИЙН ХАМГИЙН МУУ ЗАХИРЛУУД

Өнгөрсөн жилийн хувьд дэлхийн хамгийн муу ажилласан таван компанийн ерөнхий захирлыг тодруулахад гурван асуудлыг чухалчилжээ.

- Захирлын хувьд хүнд байдалд орсон эсвэл хүнд байдалд орох эрсдэлд хүрсэн, ажлын гүйцэтгэлийн хувьд огцом уналт бий болсон эсэх, хувьцааны ханшийн уналт, бэлэн мөнгөний чадавх, зах зээлд эзлэх байр суурь, болон бусад санхүүгийн үзүүлэлт
- Хөлгийг буруу зүгт залж байгааг мэдэж байсан эсвэл мэдэж болох байсан эсэх
- Тухайн компанийн захирлын үйлдэл эсвэл идэвхгүй байдал нь корпорацийн засаглал болон стратегийн удирдлагыг эвдсэн эсэх

Захирлуудын гүйцэтгэлийг үнэлэхдээ томоохон бүтэлгүйтэл болон уналт нь тухайн удирдлагын хяналтаас давсан хүчин зүйл байсан бол гүйцэтгэх албан тушаалтны бурууд тооцоогүй болно.



“Microsoft” компанийн ерөнхий захирал Стив Балмер



Стив Балмерыг гүйцэтгэх захирлаар сонгосон нь маргаантай өөрчлөлт байж мэдэх. Учир нь, түүний удирдан авч яваа компани жил бүр 20 тэрбум ам.долларын алдагдал хүлээсээр байгаа билээ.

“Microsoft” компанийг үүсгэн байгуулагч Билл Гейтс 2000 онд Стив Балмерт үнэт өв болох компанийнхаа удирдлагыг шилжүүлэн өгснөөр түүний эрин эхэлсэн. Гэвч амжилттай явж байсан компанийг илүү удирдаж чадалгүй уналтанд оруулсан нь гайхмаар.

Зах зээлдээ монополий байр сууринд ойртож, асар их мөнгөний эх үүсвэрт хүрэхээр зэхэж байсан Персонал компьютерийн онцгой эрхэт тус компанийг тэрбээр залгамжилж авсан. “Microsoft” компани нь Хятад, Энэтхэг, Орос Бразиль тэргүүтэй олон улсад хүрээгээ тэлж, мега есөлтөөс атгаад алдсан.

Балмер болон “Microsoft” зах зээлээ

нэг, нэгээр нь алдаж эхэлсэн. Зах зээлд “Zune” хэмээх хөгжим тоглуулагчийнхаа байр суурийг “Apple” компанийн “iPod” тоглуулагчид алдсан. Үүний дараа “Windows” утаснуудын орон зайг iPhone болон Android үйлдлийн системтэй бусад утас эзэлсэн. Ингээд зогсохгүй “Bing” хэмээх хайлтын системийн хэрэглэгчдийг “Google”-д алдсан байдаг. Утас бол дээрх алдсан зах зээлүүдийн хувьд хамгийн том жишээ бөгөөд бизнес эхлүүлж буй компаниуд болон өрсөлдөгчдийн хувьд цааш ахих боломжийг олгосон юм. Facebook, Google болон Tencent, Lenovo компанийн хувьд хөгжлийн дараагийн эрин рүү шилжилт хийж байгаа бол Microsoft хоцорч үлдсээр.

Стив Балмерын хувьд өнгөрсөн жил хамгийн тааруу жил нь ч биш байж мэдэх. Учир нь, тэрбээр Microsoft компанийн суудлаас энэ жил буусан нь удаан үргэлжилсэн хэцүүхэн үеийнх нь оргил болж байгаа билээ. ▶▶

“Sear” Холдингийн үүсгэн байгуулагч, захирал, хөрөнгө оруулагч Эдди Ламперт



▶ Эдди Ламперт бол Хөрөнгө оруулалтын сангийн “од”, 2003 онд Америкийн “Kmart” их дэлгүүрийг дампуурлаас гаргаж чадсан хүн билээ. Хожим нь тэрбээр “Sears” олон үндэстний их дэлгүүрийг худалдан авч “Sears” холдингийг байгуулсан. Хэдийгээр тэрбээр санхүүгийн ертөнцөд эр зориг, ур чадвараараа гайхагдсан хэвээр байгаа ч 2013 он түүний хувьд хүндхэн өнгөрсөн. Эддигийн өмнө тулгарсан уналтууд түүний худалдаж авсан 120 жилийн түүхтэй “Sears” компанийг сүйрүүлж мэдэхээр байгаа юм

“Sears” холдингийн зах зээлийн үнэлгээ энэ жил буураагүй. Гэвч “Standard & Poor’s 500” ердөө 29 хувиар өссөн бөгөөд хувьцааны үзүүлэлт ч тэр энэ хавьцаа байгаа. Тийм ч сайн үзүүлэлт биш. “Same-store sales” үзүүлэлт буюу жижиглэнгийн барааны салбарын эрүүл мэндийг илтгэдэг үзүүлэлт уруудсан хандлагатай буюу орлого буурсан.

Үүнтэй зэрэгцэн өнгөрсөн 27 улирлын турш худалдааны үзүүлэлт мөн багассан байна. Өнгөрсөн жилийн эхний гурван улиралд 800 сая ам.долларын алдагдал хүлээгээд байгаагийн зэрэгцээ тэрбээр долоон тэрбум ам.долларын өртэй.

Эдди Лампертын хувьд зардлаа хасч, үл хөдлөх хөрөнгүүдээ зарж, хувьцаагаа эргүүлэн худалдан авч өөрөөр хэлбэл, “Их авч, бага зар” гэсэн өөрийнхөө санхүүгийн зах зээлд баримталдаг тоглоомын дүрмээ дагасаар өдийг хүрсэн. Гэвч жижиглэнгийн барааны дэлгүүр бол хөрөнгө оруулалтын сан биш учир түүний тоглоомын дүрэм байгаа оносонгүй. Тиймээс өнгөрсөн жилийн хамгийн муу захирлуудын эгнээнд жагсахаас өөр сонголт түүнд үлдсэнгүй.

“Blackberry” компанийн ерөнхий захирал асан Торстон Хейнс



Жагсаалтын гуравт орж буй захирлын хувьд “Blackberry” компанийн хямралын үед ажлаа хүлээж авсан нэгэн билээ. Гар утас үйлдвэрлэгч “Blackberry” нь өрсөлдөгч iPhone болон Samsung Galaxy гар утасны өсөлтийн хурдыг гүйцэж, нөхцөл байдалд шилжилт хийж чадаагүйн улмаас “цус алдаж” эхэлсэн гэдэг. Тус компанийн үүсгэн байгуулагчид зайгаа тавьж өгсний дараа шинэ удирдлага эргэлт хийх стратегид ихээхэн шүүмжлэлтэй хандсан.

Тус компанийг хатуухан хүний гарт зангидууллаа гэж байсан ч Торстон Хейнс захирлаар ажилласан богинохон хугацаандаа компанийн нөхцөл байдлыг улам ч дордуулсан юм. Тэрбээр олны өмнө хэлсэн эхний мэдэгдэлдээ “Энэ компанид ямар ч эрс өөрчлөлтүүд хэрэггүй” гэж байлаа. Гэсэн ч тэрбээр Apple, Samsung болон Google компаниудын өрсөлдөж буй гар утасны зах зээлийн хэмнэл, хурдад хариу өгөх хэмжээнд Blackberry утасныхаа хөгжлийг хурдасгаж чадаагүй.

Ганцхан улирлын алдагдал л гэхэд нэг тэрбум ам.доллар хүрч, хэдэн мянган ажилчид ажлаасаа чөлөөлөгдөж эхлэв. Хүнд байдалд орсон тэр үед ч тус компанийг аврах хамгийн том боломж нь компаниас үлдсэн үнэт хэсгүүдийг зарах байлаа. Motorola, Ericsson болон Nokia компанийн эзэд ч зах зээл тэдний эсрэг эргэж эхлэхэд компаниа зарах арга хэмжээ авч, асар их алдагдлаас зайлж чадсан. Blackberry компанийн Канадын санхүүгийн байгууллагатай хийсэн урт удаан “бүжиг” хөрөнгө оруулалтаар эцэслэгдсэн.

Торстон Хейнс өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын 1-нд ажлаасаа чөлөөлөгдөхөд тус компанийн хувьцаа 43 хувиар унаж, Хейнсийн удирдлагын үед Blackberry нийт 60 хувийн хувьцааны уналтыг амссан байна. ▶

“JC Penney” компанийн ерөнхий захирал асан Рон Жонсон



- Шинэчлэл ямар нөлөө үзүүлэхийг туршиж ч үзэлгүй, холбогдох эрсдэлүүдийг үл тоон шинэ ерөнхий захирал 111 жилийн настай компанийнхаа үйлчлүүлэгчидтэйгээ тогтоосон харилцааг тэр аяар нь эрс өөрчлөхийг шийдсэн. Энэ хүн бол өнгөрсөн жилийн дөрөвдүгээр сард Америкийн JC Penney сүлжээ их дэлгүүрийн ерөнхий захирлын суудлаас хусагдсан Рон Жонсон юм.

Рон Жонсоны хувьд “Apple” компанийн ерөнхий захирал Стив Жобст дэлхийд тэргүүлэх жижиглэнгийн бүтээгдэхүүнийн сүлжээ дэлгүүрүүдийн нэгийг шинээр гаргаж ирэхэд тусалсан нэгэн гэдгээрээ алдаршиж, JC Penney компанид уригдсан билээ. Түүний зорилго Apple дэлгүүрийн зарчмуудыг нэвтрүүлэх байсан. Гэвч хэрэглэгчдийн тархинд гүн шингэсэн брэнд бүтээгдэхүүн, гял цал дотоод засал, өндөр үнийн зарчим нь дундаж амьдралтай иргэдийн хүрээлэлд багтдаг компанийн хэрэглэгчдэд төдийлэн наалдсангүй. Рон яг л хэрэглэгчдээ хөөж байгаа мэт үйл явдал түүний шийдвэрийг дагасан. Тэрбээр хэрэглэгчиддээ хандан “Үйлчлүүлэгчид миний стратегийг ойлгох хэмжээнд боловсрох хэрэгтэй” хэмээн доромжилсон өнгө аястай мэдэгдэл хийж байсан билээ.

“JC Penney” компанид нэг улирлын дотор хагас тэрбум ам.долларын алдагдал, хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэх дэлгүүрүүдийн борлуулалтын уналт, 4 тэрбум ам.доллараар буурсан орлого, 50 хувиар уруудсан хувьцааны үнэ, компани амьдрах эсэх нь эргэлзээт нөхцлийг Роны богино настай удирдлага авчирснаар, түүний эрин дуусгавар болсон билээ.

“EBX” группын Ерөнхийлөгч Эйкэ Батиста



Дэлхийн хамгийн баян хүмүүсийн нэг байснаа ганц жилийн хугацаанд тэрхүү хур хөрөнгийнхөө 99 хувийг алдсан хүн бол “Forbes” сэтгүүлийн баячуудын жагсаалтанд 30 тэрбум ам.долларын хөрөнгөөр наймдугаарт жагсаж байсан Экеэ Батиста юм. Бразилийн бизнес эрхлэгч Батиста нь Бразил, Канадад алтны уурхай олборлож эхэлснээр баяжсан. Тэрбээр олны хараанаас зугтдаг энгийн нэг бизнес эрхлэгч биш.

Учир нь тэрбээр “Энэ дэлхийн хамгийн баян хүн болмоор байна” хэмээн бардамнаж байсан удаа олон. Тэрбээр Play-boy сэтгүүлийн модель бүсгүйтэй гэрлэж, сая ам.долларын үнэтэй машинаа зочны өрөөндөө зогсоож, Бразилчуудын хараанд амьдардаг нэгэн байсан.

Тэрбээр 2007 онд Бразилийн Сао Паулогын эргийн ойролцоо нийт Бразилийн газрын тосны 11 жилийн үйлдвэрлэлтэй тэнцэх хэмжээний газрын тосны нөөцийг ашиглахын тулд хөрөнгө оруулагчдыг ятгаж, 10 тэрбум баррелийн, эргэн нөхөгдөх нөөц хэмээн тухайн үедээ бардам дуугарч байсан билээ. Тэрбээр газрын тос олборлох зорилгоор “OGX” компанийг байгуулан, хувьчилж, дөрвөн тэрбум ам.долларын зах зээлийн үнэлгээтэй болгосон.

Харамсалтай нь, газрын тосны нөөцийн талбайн хэмжээг хэтрүүлэн сурталчилж, давс, элс, чулууны доор буй газрын тосыг олборлох хүндрэл, зардлыг дутуу тооцсон байв. Их хэмжээний газрын тосны нөөц олсон гэх мэдэгдлийнхээ дараагаас тэрбээр санхүүжилт босгож, хэд, хэдэн компанийг байгуулсан. Түүний байгуулсан хоёр компани өнөөдөр өөрийн хөрөнгөөс хэд дахин давсан өртэй. Компанийнх нь хувьцааны ханш 95 хувиар тухайн жилдээ мөн унасан билээ.

Түүний бүтэлгүйтэл олон нийтэд ил болсон даруй тэрбээр эргэлт хийхээр шийдэх үедээ компаниуддаа авч ажиллуулсан захирлууд болон мэргэжилтнүүдэд бууруугаа тохож эхэлсэн юм. Эцэст нь тэрбээр сайн удирдагчаас илүү сайн наймаачин гэдгээ баталж, даатгалын бүтээгдэхүүн зарж сууна. ■